

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангиллын код 13.020.40

Хүлэмжийн хий- Хэсэг 2: Төслийн түвшинд хүлэмжийн хийн ялгаралтын бууралт ба шингээлтийн өсөлтийг тооцоолох, мониторинг хийх, тайлагнах тухай зааварчилсан удирдамж	MNS ISO 14064-2 : 2011
Green house gases-Part 2: Specification with guidance at the project level for quantification, monitoring and reporting of green house gasemission reductions or removal enhancements	ISO 14064-2:2006 (E)

Стандартчилал Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор батлав.

1 Хамрах хүрээ

ISO14064 олон улсын стандартын энэхүү хэсэг нь төслийн түвшинд хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах эсвэл шингээлтийн өсөлтийг бий болгох зорилго бүхий үйл ажиллагаануудын хүлэмжийн хийг тооцоолох, мониторинг хийх, тайлагнах талаар зааварчилгаа өгөх, түүнд тавигдах шаардлага, хэрэгжүүлэх зарчмуудыг тодорхойлж өгсөн болно. Энэ хэсэгт хүлэмжийн хийн төслийг төлөвлөх, суурь нөхцөл болон төсөлтэй холбоотой хүлэмжийн хийн эх үүсвэр, шингээгч, хураагуурыг сонгон тодорхойлох, хүлэмжийн хийн төслүүдийн гүйцэтгэлд мониторинг хийх, хүлэмжийн хийг тооцоолох, баримтжуулах, тайлагнах болон мэдээллийн чанарын удирдлага зэрэгт тавигдах шаардлагуудыг тусгасан юм.

ISO14064 нь дундыг баримталсан хүлэмжийн хийн хөтөлбөр юм. Хэрэв уг төсөл хүлэмжийн хийн хөтөлбөрийн хүрээнд хамрагдаж байгаа бол уг хөтөлбөрийн шаардлага ISO14064-ын шаардлага дээр нэмэлт болж орно.

Тайлбар: Хэрэв ISO14064 стандартын шаардлага нь хүлэмжийн хийн төсөл хэрэгжүүлэгч болон байгууллагын хүлэмжийн хийн хөтөлбөрийн шаардлагын дагуу үйл ажиллагаагаа явуулахад нь хориг, саад болох тохиолдолд хүлэмжийн хийн хөтөлбөрийн шаардлага давуу эрхээр мөрдөгдөнө.

2 Нэр томъёо, тодорхойлолт

Энэ баримт бичиг дэх нэр томъёо, тодорхойлолтыг дараахи утгаар ойлгоно.

2.1

Хүлэмжийн хий (ХүХ)

Дэлхийн гадарга, агаар мандал болон үүлнээс цацардаг нил улаан туяаны тодорхой долгионы урттай хэсэгт цацрагийг ялгаруулдаг ба шингээдэг, байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүсэн бий болсон, агаар мандалын хийн хэсгийг хүлэмжийн хий гэнэ.

MNS ISO 14064-2 : 2011

Тайлбар: ХүХ- д нүүрсхүчлийн хий (CO₂), намгийн хий (CH₄), азотын исэл (N₂O), устфторт нүүрстөрөгчийн нэгдэлүүд (HFC_s), перфторт нүүрстөрөгчийн нэгдэлүүд (PFCs), гексафторт хүхэр (SF₆) зэрэг орно.

2.2

Хүлэмжийн хийн эх үүсвэр

Агаар мандалд ХүХ-г ялгаруулдаг физик нэгж буюу үйл явц

2.3

Хүлэмжийн хийн шингээгч

Агаар мандлаас ХүХ-г шингээдэг физик нэгж буюу үйл явц

2.4

Хүлэмжийн хийн хураагуур

ХүХ-н эх үүсвэрээс (2.2) баригдсан эсвэл ХүХ-н шингээгчийн (2.3) тусламжтайгаар агаар мандал дахь хүлэмжийн хийг агуулах, хуримтлуулах чадвартай биомандал, геомандал, усан мандлын бүрэлдхүүн хэсэг буюу физик нэгж

Тайлбар 1. Тухайн цаг хугацаанд ХүХ-н хураагуурт агуулагдах нүүрсхүчлийн нийт хэмжээг хураагуурын нүүрсхүчлийн нөөц гэнэ.

Тайлбар 2. Хүлэмжийн хийн нэг хураагуур нөгөө хураагуурт хүлэмжийн хий шилжүүлж болно.

Тайлбар 3. ХүХ-н эх үүсвэрээс ялгарах ХүХ-г агаар мандалд алдагдахаас өмнө ХүХ-н хураагуурт цуглуулснаар бий болох ХүХ-н хуримтлалыг ХүХ-н хуримтлал ба хадгалалт гэж нэрлэнэ.

2.5

ХүХ-н ялгаралт

Тодорхой цаг хугацаанд агаар мандалд ялгарсан нийт ХүХ-н хэмжээ

2.6

Хүлэмжийн хийн шингээлт

Тодорхой цаг хугацаанд агаар мандлаас зайлуулагдсан нийт ХүХ-н хэмжээ

2.7

ХүХ-н ялгаралтын бууралт

Төсөл болон суурь нөхцөл(2.19)-ийн ХүХ-н ялгаралтын зөрөөгөөр тооцоологдсон ХүХ-н бууралт

2.8

ХүХ-н шингээлтийн өсөлт

Төсөл ба суурь нөхцөл (2.19)-ийн ХүХ-н шингээлтийн зөрөөгөөр тооцоологдсон ХүХ-н шингээлт

2.9

ХүХ-н ялгаралт ба шингээлтийн итгэлцүүр

Үйл ажиллагааны өгөгдлүүдтэй ХүХ-н ялгаралт ба шингээлтийг холбох итгэлцүүр
Тайлбар: ХүХ-н ялгаралт ба шингээлтийн итгэлцүүрт урвалын итгэлцүүрүүд орж болно.

2.10

ХүХ-н мэдэгдэл

Баримт, бодит байдалд тулгуурласан хариуцагч талын албан ёсны баталгаа буюу мэдэгдэл

Тайлбар 1. ХүХ-н баталгаа нь тухайн цаг хугацаа эсвэл тодорхой цаг хугацааны турших хүлэмжийн хийн мэдээллийг илэрхийлж болно.

Тайлбар 2. ХүХ-н баталгаа нь магадлагч (2.27) эсвэл нотлогчийн (2.29) шаардлагад нийцсэн шалгуур үзүүлэлтээр хэмжигдэж, үнэлэгдэж, нотлогдож болохуйц байх шаардлагатай.

Тайлбар 3. ХүХ-н баталгааг ХүХ-н төслийн төлөвлөгөө эсвэл хүлэмжийн хийн тайлангийн (2.15) хэлбэрээр бэлтгэсэн байж болно.

2.11

ХүХ-н мэдээллийн систем

ХүХ-н мэдээллийг бий болгох, тогтвортой хөтлөх, удирдах талаар бодлого, журам, үйл явц

2.12

ХүХ-н төсөл

ХүХ-н ялгаралтыг бууруулах (2.7) ХүХ-н шингээлтийг нэмэгдүүлэх (2.8) зорилгоор суурь нөхцөлд тусгагдсан нөхцлийг өөрчлөх үйл ажиллагаа буюу үйл ажиллагаанууд

2.13

ХүХ-н төсөл хэрэгжүүлэгч

ХүХ-н төслийг (2.12) бүхэлд нь хариуцах, хянах байгууллага буюу хувь хүн

2.14

ХүХ-н хөтөлбөр

Байгууллага эсвэл хүлэмжийн хийн төслийн (2.12) үйл ажиллагаанаас гадуурхи ХүХ-н ялгаралт ба шингээлт, ялгаралтын бууралт (2.7) болон шингээлтийн өсөлтийг (2.8) бүртгэж, тооцоолж, удирдах сайн дурын буюу албан ёсны олон улсын, үндэсний эсвэл бүсийн тогтолцоо

2.15

ХүХ-н тайлан

MNS ISO 14064-2 : 2011

Зорилтот хэрэглэгчидэд (2.22) байгууллага буюу төслийн ХүХ-тэй холбоотой мэдээллийг хүргэх зориулалтаар боловсруулсан бие даасан баримт бичиг

Тайлбар: ХүХ-н тайланд ХүХ-н баталгаа орж болно.

2.16

Нөлөөлөлд өртсөн ХүХ-н эх үүсвэр, шингээгч болон хураагуур

Төслийн үйл ажиллагаанд холбогдох бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн эсвэл физик өөрчлөлт нөлөөлсөний улмаас үүссэн ХүХ-н эх үүсвэр, шингээгч ба хураагуур

Тайлбар 1: ХүХ-н эх үүсвэр, шингээгч, хураагуур нь ХүХ-н төсөлтэй холбоотой байхад нөлөөлөлд өртсөн ХүХ-н эх үүсвэр, шингээгч, хураагуур нь зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн өөрчлөлтөөр ХүХ-н төсөлтэй холбогдоно.

Тайлбар 2: Нөлөөлөлд өртсөн ХүХ-н эх үүсвэр, шингээгч болон хураагуур нь ерөнхийдөө төсөл хэрэгжиж буй газрын гадна байрладаг.

Тайлбар 3: Нөлөөлөлд өртсөн ХүХ-н эх үүсвэр, шингээгч, хураагуураас бий болох ХүХ-н ялгаралтын бууралт, шингээлтийн өсөлтийг алдагдах ялгаралт гэж нэрлэдэг.

2.17

Хяналттай ХүХ-н эх үүсвэр, шингээгч ба хураагуур

Санхүү, бодлого, удирдлага болон өөр бусад хэлбэрээр ХүХ-ийн төсөл хэрэгжүүлэгчийн (2.13) нөлөө болон зааврын дор үйл ажиллагаа нь явагддаг ХүХ-н эх үүсвэр, шингээгч ба хураагуур

Тайлбар: Хяналттай ХүХ-н эх үүсвэр, шингээгч ба хураагуур нь ерөнхийдөө төсөл хэрэгжиж буй газар байдаг.

2.18

Холбогдох ХүХ-н эх үүсвэр, шингээгч ба хураагуур

Төслийн хүрээнд эсвэл төслөөс гадагшаа ба дотогшоо чиглэсэн материал, энергийн урсгал бүхий ХүХ-н эх үүсвэр, шингээгч ба хураагуур

Тайлбар 1: Холбогдох ХүХ-н эх үүсвэр, шингээгч ба хураагуур нь төсөл руу эсвэл төслөөс гадагшаа чиглэлтэй байхаас гадна төсөл хэрэгжиж буй газарт эсвэл түүний гадна байж болно.

Тайлбар 2: Холбогдох ХүХ-н эх үүсвэр, шингээгч ба хураагуурын үйл ажиллагаанд төслийг боловсруулах, хэрэгжүүлэх, дуусгах зэрэг үйл ажиллагаа орж болно.

2.19

Суурь нөхцөл

Санал болгож байгаа ХүХ-н төсөл хэрэгжихгүй байх үед нөхцөл байдал ямар байхыг хамгийн бодитоор илэрхийлсэн таамаглалт нөхцөл байдал (2.12).

Тайлбар: Суурь нөхцөл нь ХүХ-н төслийн цаг хугацаатай давхцаж байдаг.

2.20**Дэлхийн дулаарлын чадамж (ДДЧ)**

Тодорхой хугацаанд нэгж ХүХ-ийн агаар мандалд үзүүлэх дулаарлын нөлөөллийг нүүрсхүчлийн хийн эквивалентаар илэрхийлсэн утга

Тайлбар: Хавсралт Б хэсэгт Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх засгийн газар хоорондын мэргэжилтний хорооноос гаргасан ДДЧ-ийг үзүүлэв.

2.21**Нүүрсхүчлийн хийн эквивалент****CO₂ e**

Тухайн ХүХ-г нүүрсхүчлийн хийн дэлхийн дулаарлын чадамжтай харьцуулсан нэгж

Тайлбар 1: Нүүрсхүчлийн хийн эквивалентийг тооцоолохдоо тухайн ХүХ-н хэмжээг дэлхийн дулаарлын чадамжаар (2.20) үржүүлж гаргадаг.

Тайлбар 2: Хавсралт Б хэсэгт Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх засгийн газар хоорондын мэргэжилтэний хорооноос гаргасан ДДЧ-ийг үзүүлэв.

2.22**Зорилтот хэрэглэгч**

Шийдвэр гаргахдаа ХүХ-тэй холбоотой мэдээллийг ашигладаг, ХүХ-тэй холбоотой тайланг гаргагчдын тогтоосон хувь хүн буюу байгууллага

Тайлбар: Захиалагч, хариуцагч тал, ХүХ-н хөтөлбөрийн зохицуулагч, зохион байгуулагч, санхүүгийн хороо, бусад хамаарагч талууд (2.23) (ө.х: орон нутгийн бүлэг хүмүүс, төрийн захиргааны байгууллага буюу төрийн бус байгууллага)-ийн аль нь ч зорилтот хэрэглэгч байж болно

2.23**Оролцогч тал**

ХүХ-н төсөл (2.12) боловсруулах түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд өртөж буй хувь хүн буюу байгууллага

2.24**Баталгаат байдлын түвшин**

Зорилтот хэрэглэгч(2.22)-ээс магадлагаа (2.26) буюу нотолгоо (2.28)нд тавьж буй баталгаат байдлын хэм хэмжээ

ТАЙЛБАР 1 Аливаа нэгэн материалын алдаа, орхигдуулсан буюу буруу хөрвүүлсэн зүйл байгаа эсэхийг тогтоох үүднээс магадлаа гаргагч буюу нотолгоо гаргагчийн боловсруулсан магадлагаа буюу нотолгооны төлөвлөгөөний нарийвчлалын зэрэглэлийг тодорхойлоход баталгаат байдлын түвшинг ашигладаг.

ТАЙЛБАР 2 Магадлагаа ба нотолгоонд өөр өөр үгээр бичигддэг баталгаат байдлын хоёр түвшин (байж болох болон хязгаарлагдмал) байдаг. Магадлагаа

MNS ISO 14064-2 : 2011

болон нотолгооны мэдэгдлүүдийн жишээнүүдийг ISO 14064-3:2006, А.2.3.2-т үзүүлэв.

2.25

Мониторинг

ХүХ-ийн ялгаралт, шингээлт болон ХүХ-н холбогдолтой бусад өгөгдөлд байнга эсвэл тодорхой хугацаанд хийх үнэлгээ

2.26

Магадлагаа

ХүХ-н төслийн төлөвлөгөөнд тусгагдсан хүлэмжийн хийн мэдэгдлийг (2.10) зөвшөөрсөн магадлагааны шалгууртай (2.32) харьцуулах замаар үнэлгээ хийх системчлэгдсэн, бие даасан бөгөөд баримтжуулалт бүхий үйл явц

ТАЙЛБАР 1 Зарим тохиолдолд (анхдагч талын магадлагаа хийх үед) бие даасан байдал нь ХүХ-н өгөгдөл, мэдээллийг боловсруулах хариуцлагаас чөлөөлөгдсөн байдлаар хангагдаж болно.

ТАЙЛБАР 2 ХүХ-н төслийн төлөвлөгөөний агуулгыг 5.2-т үзүүлэв.

2.27

Магадлагч

Магадлагааны үйл ажиллагааг гүйцэтгэх, үр дүнгээ тайлагнах үүрэг бүхий бие даасан, бусдаас хараат бус, чадварлаг хувь хүн буюу хүмүүс

Тайлбар: Магадлагч нь магадлагаа хийх тал гэсэн нэр томъёогоор орж болно.

2.28

Нотолгоо

Хүлэмжийн хийн баталгааг (2.10) зөвшөөрсөн нотолгооны шалгууртай харьцуулах замаар үнэлгээ хийх бие даасан, системчлэгдсэн, баримтжуулалт бүхий үйл явц

ТАЙЛБАР Зарим тохиолдолд (анхдагч талын нотолгоо хийх үед) бие даасан байдал нь ХүХ-н өгөгдөл, мэдээллийг боловсруулах хариуцлагаас чөлөөлөгдсөн байдлаар хангагдаж болно.

2.29

Нотлогч

Нотолгооны үйл ажиллагааг гүйцэтгэх, үр дүнгээ тайлагнах үүрэг бүхий бие даасан, бусдаас хараат бус, чадварлаг хувь хүн буюу хүмүүс

Тайлбар: Нотлогч нь нотолгоо хийх тал гэсэн нэр томъёогоор орж болно.

2.30

Тодорхой бус байдал

Тооцоологдсон утгатай холбоотойгоор гарч болох зөрөө утгуудын тархалтыг тодорхойлсон тооцооллын үр дүнтэй холбогдох үзүүлэлт

ТАЙЛБАР Тодорхой бус байдлын тухай мэдээлэл нь ихэвчлэн утгуудын боломжит тархалтын талаар тоон болон тархалтын боломжит учир шалтгааны талаар чанарын мэдээлэл байдаг.

3 Зарчимууд

3.1 Ерөнхий

ХүХ-н холбогдолтой мэдээлэл нь үнэн бөгөөд зөв тодорхойлогдсон гэдгийг бататгахын тулд тодорхой зарчмуудыг зайлшгүй баримтлах ёстой. Эдгээр зарчмууд нь ISO14064 стандартын энэхүү хэсэгт заасан шаардлага, түүнийг даган мөрдөх зааварчлага болно.

3.2 Хамааралтай байдал

Зорилтот хэрэглэгчийн хэрэгцээнд тохирох ХүХ-н эх үүсвэр, ХүХ-н шингээгч, ХүХ хураагуур, өгөгдөл болон аргачлалыг сонгох

3.3 Цогц байдал

Холбогдох бүх ХүХ-н ялгаралт ба шингээлтийг хамруулах. Мөн шалгуур үзүүлэлт, баримтлах журамтай холбоотой холбогдох бүх мэдээллийг багтаасан байх.

3.4 Хоорондын уялдаа холбоотой байдал

ХүХ-тэй холбогдох мэдээлэл нь утга төгөлдөр харьцуулалт хийх боломж олгож байх

3.5 Үнэн зөв байдал

Алдаа мадаг, тодорхой бус байдлыг байж болох хамгийн бага түвшинд байлгах

3.6 Ил тод байдал

Зорилтот хэрэглэгчийг зохих ёсны итгэл үнэмшилтэйгээр шийдвэр гаргах боломжоор хангахын тулд, ХүХ-н холбогдолтой хэрэгцээтэй мэдээллийг хангалттай хэмжээнд ил тод байлгах

3.7 Консерватив байдал


ХүХ-н ялгаралтын бууралт, шингээлтийн өсөлтийг хэтрүүлж тооцоолохгүй байхын тулд ХүХ-н ялгаралтын бууралт, шингээлтийг аль болох багаар тооцоолох таамаглал, утга, журмыг хэрэглэх

4 ХүХ-н төслийн танилцуулга

ХүХ-н төслийн мөчлөг (цикл) нь төлөвлөлтийн ба хэрэгжилтийн гэсэн хоёр үе шатаас бүрдэнэ. Төслийн хэмжээ, мөрдөгдөж буй хууль эрх зүй зэрэг тухайн нөхцөл байдал ХүХ-н хөтөлбөр, стандартууд зэргээс хамаарч ХүХ-н төслийн мөчлөгийн үе шат нь өөр өөр байна. ISO 14064-ын энэхүү хэсэгт төслийн ХүХ-н тооцоолох, мониторинг хийх, тайлан гаргахад тавигдах шаардлагуудыг

MNS ISO 14064-2 : 2011

тодорхойлсон. ХүХ-н төслийн ерөнхий мөчлөгт зураг 2-т үзүүлсэн нэмэлт элементүүд орж болдог.



Тайлбар 1. Зураг 1-т үзүүлсэн элементүүдийг ХүХ-н бүх хөтөлбөрүүд агуулсан байх шаардлагагүй.

Тайлбар 2. ХүХ-г тооцоолоход тодорхой ХүХ-н нэгжийг хэрэглэнэ. Баталгаат ялгаралтын бууралт, ялгарлын бууралт, кредит оноо, баланс зэрэг нэгжийг түгээмэл хэрэглэдэг ба эдгээр нь тонн нүүрсхүчлийн хийн эквивалентаар (тн. CO_{2e}) илэрхийлэгддэг.

Зураг 2 - ХүХ-н төслийн мөчлөг

ХүХ-н төсөл хэрэгжүүлэгч эхлээд төслийн үзэл баримтлалыг тодорхойлох, төсөл боловсруулах, төслийн техник эдийн засгийн үндэслэл буюу хэрэгжих бодит байдалд үнэлгээг хийх, оролцогч талуудтай зөвлөлдөх, ХүХ-н хөтөлбөрт хамрагдах шаардлагад нийцсэн эсэхэд үнэлгээ хийнэ. Төсөл хэрэгжүүлэгч төслийн батламж эсвэл зөвшөөрсөн бичгийг холбогдох ХүХ-н хөтөлбөр эсвэл төрийн байгууллагаас авч болно.

Төслийн төлөвлөлтийн үе шатанд ХүХ-н төслийг боловсруулах, түүнийг баримтжуулах үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тусгасан. Төсөл хэрэгжүүлэгч дараахи үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Төслөө танилцуулах

-Төслийн ХүХ-н эх үүсвэр, шингээлт, хураагуурыг сонгох, тодорхойлох

- Суурь нөхцлийг тодорхойлох

-ХүХ-н ялгаралт, шингээлт, ялгаралтын бууралт болон шингээлтийн өсөлтийг тооцоолох, хянах, тайлагнах журмуудыг боловсруулах

ХүХ-н хөтөлбөрөөс тухайн ХүХ-н төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө төслийн албан ёсны бүртгэл, төслийн магадлагаа, төслийн төлөвлөгөөг олон нийтэд ил тод байлгах, тараахыг шаардаж болно.

Төсөл хэрэгжүүлэх үе шатанд ХүХ-н ялгаралт, шингээлт, ялгаралтын бууралт, шингээлтийн өсөлтийн мэдээллийн чанарын удирдлагыг тогтмол хэрэгжүүлэх, мониторинг хийх, тооцоолох, тайлагнах үйл ажиллагааны журам, шалгуур үзүүлэлтийг сонгох, ашиглахад тавигдах шаардлагуудыг ISO14064 стандартад заасан байдаг.

ХүХ-н төслийн үйл ажиллагаа тодорхой үйл ажиллагаанаас (жишээ нь тоног төхөөрөмж суурилуулах, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд оролцох эсвэл эхлүүлэх) эхэлж тодорхой үйл ажиллагаагаар (гүйцээх, хаах, зогсоох эсвэл албан ёсоор төслөө дуусгах) дуусгавар болдог.

ХүХ-н төсөл/ХүХ-н хөтөлбөрийн онцлог байдлаас хамааран үйл ажиллагааны тайлангийн хугацаа, тайлан гаргах давтамж харилцан адилгүй байна. Төсөл хэрэгжих хугацаанд хийсэн хяналт шинжилгээ, болон бусад цуглуулсан мэдээ мэдээлэл дээр тулгуурлан ХүХ-н ялгаралт, шингээлт, ялгаралтын бууралт болон шингээлтийн өсөлт зэргийг баталгаажуулах шаардлагатай. ХүХ-н хөтөлбөрийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн ХүХ-н нэгжийг бий болгохын тулд төсөл хэрэгжүүлэгч нотлогдсон ХүХ-н ялгаралтын бууралт, шингээлтийн өсөлтийн утгыг ХүХ-н хөтөлбөрт мэдэгдэх ёстой. ХүХ-н нэгж (өөрөөр хэлбэл кредит)-ийг баталгаажуулах асуудал бол ISO14064-ийн энэ хэсгийн хүрээнд хамрагдахгүй.

Янз бүрийн төрөл, хэмжээ бүхий ХүХ-н төслүүдийг хамрах үүднээс ISO14064-ийн энэ хэсэг нь тодорхой шалгуур үзүүлэлт, журмыг гаргаж өгөхөөс зайлсхийж харин үйл ажиллагаанд тавигдах шаардлага, зарчмуудыг тусгасан. Тиймээс ISO14064-ийн энэхүү хэсгийг даган мөрдөхөд онцгой ач холбогдолтой холбогдох хууль дүрмийн зааварчилгаа, нэмэлт шаардлага, шалгуур үзүүлэлт, ХүХ-н хөтөлбөрүүд, сайн туршлага, стандартыг Зураг 3-д үзүүлэв.



Зураг 3 – ISO 14064-2 стандартын хэрэглээний ерөнхий бүдүүвч

Зураг 4-т ISO 14064-ийн энэ хэсгийн шаардлагад нийцсэн төслийн төлөвлөлтийн болон хэрэгжилтийн үе шат хоорондын уялдааг үзүүлэв. Хэрэглэгч ISO 14064-ийн энэ хэсгийг хэрэглэхдээ тавигдах шаардлагуудын хүрээнд шаталсан хандлагаас илүүтэйгээр нэгдмэл, дахин давталт бүхий хандлагаар хандаж хэрэглэх нь зүйтэй юм.

	Төлөвлөлтийн үе шат	Хэрэгжилтийн үе шат
	5.1 Ерөнхий шаардлагууд	
5.2 Төслийн танилцуулга	Боловсруулах	Мэдээллийг шинэчлэх
5.3 Төслийн ХүХ-н эх үүсвэр, шингээлт, хураагуурыг сонгох, тодорхойлох	Шалгуур үзүүлэлт, журамыг сонгох, боловсруулах, хэрэглэх	-
5.4 Суурь нөхцөлийг тодорхойлох	Шалгуур үзүүлэлт, журамыг сонгох, боловсруулах, хэрэглэх	Мэдээллийг шинэчлэх
5.5 Суурь нөхцөлийн ХүХ-н эх үүсвэр, шингээлт, хураагуурыг тодорхойлох	Шалгуур үзүүлэлт, журамыг сонгох, боловсруулах, хэрэглэх	-

5.6 Мониторнг болон тооцоонд хэрэглэх ХүХ-н эх үүсвэр, шингээлт, хураагуурыг сонгох	Шалгуур үзүүлэлт, журамыг сонгох, боловсруулах, хэрэглэх	-
5.7 Ялгаралт ба\ эсвэл шингээлтийг тооцоолох	Шалгуур үзүүлэлт, журамыг сонгох, боловсруулах	Шалгуур үзүүлэлт, журамыг хэрэглэх
5.8 Ялгаралтын бууралт ба шингээлтийн өсөлтийг тооцоолох	Шалгуур үзүүлэлт, журамыг сонгох, боловсруулах	Шалгуур үзүүлэлт, журамыг хэрэглэх
5.9 Мэдээ, мэдээллийн чанарын удирдлагыг хангах	Шалгуур үзүүлэлт, журамыг сонгох, боловсруулах	Шалгуур үзүүлэлт, журамыг хэрэглэх
5.10 ХүХ-н төслийг хянах	Шалгуур үзүүлэлт, журамыг сонгох, боловсруулах	Шалгуур үзүүлэлт, журамыг хэрэглэх
5.11 ХүХ-н төслийг баримтжуулах	Шалгуур үзүүлэлт, журамыг сонгох, боловсруулах	Шалгуур үзүүлэлт, журамыг хэрэглэх
5.12 Магадлах ба /эсвэл нотлох	ХүХ-н төслийг магадлах	Ялгаралтын бууралт болон шингээлтийн өсөлтийг нотлох
5.13 ХүХ-н төслийг тайлагнах	Шалгуур үзүүлэлт, журамыг боловсруулж, бий болгох	Шалгуур үзүүлэлт, журамыг хэрэглэх

Зураг 4 - Төлөвлөлт, хэрэгжилтэнд тавигдах шаардлагуудын харилцан уялдаа

5 ХүХ-н төсөлд тавигдах шаардлага

5.1 Ерөнхий шаардлага

Төсөл хэрэгжүүлэгч нь уг төсөл ХүХ-н хөтөлбөрийн холбогдох шаардлагууд тэр дундаа зөвшөөрлийн шалгуур үзүүлэлтийг хангах, холбогдох хууль эрх зүй, бусад шаардлагуудад нийцэж байгаа эсэхийн баталгааг ханган ажиллана.

Энэ заалтын нарийвчилсан шаардлагыг биелүүлэхийн тулд төсөл хэрэгжүүлэгч нь өөрийн төслийн үйл ажиллагаанд баримтлах тухайн үеийн сайн туршлагыг сонгон авч, үйл ажиллагаандаа хэрэглэнэ. Төсөл хэрэгжүүлэгч нь олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн эх үүсвэрийн, хэрэв боломжтой бол сайн туршлагын шалгуур үзүүлэлт, журмыг сонгон авч өөрийн үйл ажиллагаандаа хэрэглэнэ.

MNS ISO 14064-2 : 2011

Хэрэв төсөл хэрэгжүүлэгчийн сонгосон шалгуур үзүүлэлт, журам нь олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн сайн туршлагаас өөр байх тохиолдолд тэдгээрийн ялгаатай байдлыг тайлбарлах шаардлагатай.

Нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн нэг ба түүнээс дээш тооны сайн туршлагын шалгуур үзүүлэлт, журмыг ашиглаж байгаа тохиолдолд төсөл хэрэгжүүлэгч сонголт хийсэн шалтгаанаа тайлбарлах хэрэгтэй.

Хэрэв төсөлтэй холбогдох хүлээн зөвшөөрөгдсөн сайн туршлага байхгүй байх тохиолдолд төсөл хэрэгжүүлэгч ISO 14064-ын энэхүү шаардлагыг хангах шалгуур үзүүлэлт, журмыг боловсруулж, хэрэгжүүлэх ёстой.

5.2 Төслийн танилцуулга

Төсөл хэрэгжүүлэгч нь ХҮХ-н төсөл болон түүний төлөвлөгөөг дараахи агуулгатайгаар тодорхойлно. Үүнд:

- a. Төслийн нэр, зорилго, зорилтууд;
- b. ХҮХ-н төслийн хэлбэр;
- c. Төслийн байршил; Үүнд төслийн талбайн хүрээ, түүний онцлог байдлыг илэрхийлсэн газарзүйн болон физик мэдээлэл;
- d. Төсөл эхлэхээс өмнөх нөхцөл байдал;
- e. Төсөл ХҮХ-н ялгаралтыг бууруулах ба/буюу шингээлтийг нэмэгдүүлэх зорилгыг хэрхэн биелүүлэхээ тодорхойлох;
- f. Төслийн технологи, бүтээгдэхүүн, үйлчилгээ, хэрэгжүүлэх үйл ажиллагаа;
- g. ХҮХ-н төслийн үр дүнд бий болох ХҮХ-н ялгаралтын бууралт, шингээлтийн өсөлтийг тонн CO₂eq нэгжээр илэрхийлэх;
- h. Төсөл хэрэгжих үед ХҮХ-н ялгаралтын бууралт, шингээлтийн өсөлтөд нөлөөлж болох эрсдлүүдийг тодорхойлох;
- i. ХҮХ-н төсөлтэй холбоотой ХҮХ-н хөтөлбөрүүдийн ажилтнууд, төсөл хэрэгжүүлэгч, холбогдох зохицуулагчид, төслийн удирдлага, бусад төслийн оролцогчидийн үүрэг хариуцлага, холбоо барих мэдээлэл;
- j. ХҮХ-н хөтөлбөр дэхь ХҮХ-н төсөлтэй холбоотой мэдээлэл, ялгаралтын бууралт, шингээлтийн өсөлтийн тооцоо; хууль зүй, техник, эдийн засаг, салбар, нийгэм, байгаль орчин, газарзүй, төслийн талбай, цаг үеийн мэдээлэл;
- k. Холбогдох хууль эрх зүйн шаардлагаар хийгдсэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт;
- l. Оролцогч талуудын санал зөвлөмж, олон нийттэй харьцах байнгын механизм;
- m. Төсөл эхлэхээс дуусах хүртлэх төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөл хэрэгжүүлэх хугацаанд мониторинг хийх, тайлан гаргах давтамж, төслийн мөчлөгийн үе шат бүрд хэрэгжүүлэх арга хэмжээ

5.3 Төслийн ХҮХ-н эх үүсвэр, шингээгч болон хураагуурыг тодорхойлох

Төсөл хэрэгжүүлэгч төсөлтэй холбоотой төслийн хяналт, нөлөөнд байгаа ХҮХ-н эх үүсвэр, шингээгч болон хураагуурыг тодорхойлох, үнэлэх шалгуур үзүүлэлт, журмыг сонгож бий болгоно.

Төсөл хэрэгжүүлэгч нь сонгосон эсвэл тогтсон шалгуур үзүүлэлт, журмын дагуу

- а) Төсөл хэрэгжүүлэгчийн удирдлага дор хянагддаг,
- б) ХүХ-н төсөлтэй холбоотой,
- в) ХүХ-н төслийн нөлөөнд байгаа ХүХ-н эх үүсвэр, шингээгч болон хураагуурыг тодорхойлно.

5.4 Суурь нөхцлийг тодорхойлох

Төсөл хэрэгжүүлэгч дараахи зүйлийг харгалзан үзэж боломжит суурь нөхцлийг тодорхойлох, үнэлэх шалгуур үзүүлэлт, журмыг сонгон хэрэгжүүлнэ. Үүнд:

- а) Тодорхойлогдсон ХүХ-н эх үүсвэр, шингээгч, хураагуур зэргийг хамруулсан төслийн тодорхойлолт (5.3-т үзүүлэв);
- б) Одоогийн байгаа төсөл эсвэл ижил бүтээгдэхүүн, үйлчилгээ, арга хэмжээг хэрэгжүүлэх төслийн хэлбэрүүд, үйл ажиллагаа, технологиуд;
- в) Мэдээ, мэдээллийн олдоц, найдвартай байдал, хязгаарлагдмал байдал;
- д) Хууль эрх зүй, техник, эдийн засаг, нийгэм соёл, байгаль орчин, газарзүй, төсөл хэрэгжиж буй газар, цаг үеийн өнөө болон ирээдүйн нөхцөл байдлын мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч нь суурь нөхцөл ба төсөлд ижил үйл ажиллагааны төрөл, түвшин, бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэснээ батлах ба ихээхэн ялгаатай үйл ажиллагааны төрөл, түвшин, бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэсэн бол түүндээ тайлбар хийнэ.

Төсөл хэрэгжүүлэгч нь суурь нөхцлийг тодорхойлох шалгуур үзүүлэлт, журмыг сонгох, тодорхойлох, мөрдөх болно.

Тайлбар: Төсөлд суурилсан аргаар суурь нөхцөлийг төсөл хэрэгжихгүй байх үед нөхцөл байдал ямар байхаар тодорхойлдог бол ХүХ-н хөтөлбөр нь гүйцэтгэлд суурилсан аргаар суурь нөхцөлийг (жишиг нөхцөл, олон төслийн үр дүн) тодорхойлж болдог.

Төсөл хэрэгжүүлэгч суурь нөхцлийг тодорхойлохдоо ХүХ-н ялгаралтын бууралт, шингээлтийн өсөлтийг хэтрүүлж тооцоолохгүй байх таамаглал, утга, журмыг сонгох шаардлагатай.

Төсөл хэрэгжүүлэгч төслийн ХүХ-н ялгаралтын бууралт, шингээлтийн өсөлт нь суурь нөхцөл байдлаас хэрхэн ялгаатай байгааг харуулах шалгуур үзүүлэлт, журмыг сонгон, боловсруулж, сайжруулан хэрэгжүүлэх шаардлагатай.

5.5 Суурь нөхцлийн ХүХ-н эх үүсвэр, шингээгч болон хураагуурыг тодорхойлох

Суурь нөхцлийн ХүХ-н эх үүсвэр, шингээгч болон хураагуурыг тодорхойлоход төсөл хэрэгжүүлэгч дараахи үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Үүнд:

- а) Төслийн ХүХ-н эх үүсвэр, шингээгч болон хураагуурыг тодорхойлоход хэрэглэх шалгуур үзүүлэлт, журмыг олж тогтоох;

MNS ISO 14064-2 : 2011

б) Шаардлагатай тохиолдолд суурь нөхцлийн ХүХ-н эх үүсвэр, шингээгч болон хураагуурыг тодорхойлох нэмэлт шалгуур үзүүлэлтийг үйл ажиллагаандаа хэрэглэх, түүндээ тайлбар өгөх;

в) Суурь нөхцлийн ХүХ-н эх үүсвэр, шингээгч болон хураагуурыг төслийн ХүХ-н эх үүсвэр, шингээгч болон хураагууртай харьцуулах;

5.6 ХүХ-н ялгаралт ба шингээлтийг тооцоолох болон мониторинг хийх, ХүХ-н эх үүсвэр, шингээгч болон хураагуурыг сонгох

Төсөл хэрэгжүүлэгч нь байнгын мониторинг болон тооцоо хийх ХүХ-н эх үүсвэр, шингээгч болон хураагуурыг хэрхэн сонгоход ашиглах шалгуур үзүүлэлт, журмыг сонгон бий болгоно.

Төсөл хэрэгжүүлэгч байнгын мониторинг хийгдэхгүй ХүХ-н эх үүсвэр, шингээгч, хураагуурын тухай тайлбарлах шаардлагатай.

Тайлбар: Зураг А.2-т ХүХ-н ялгаралт болон шингээлтийг тооцоолох эсвэл байнгын мониторинг хийх ХүХ-н эх үүсвэр, шингээгч, хураагуурыг сонгох, тодорхойлох хүрээг үзүүлэв.

5.7 ХүХ-н ялгаралт ба /буюу шингээлтийг тооцоолох

Төсөл хэрэгжүүлэгч сонгогдсон ХүХ-н эх үүсвэр, шингээгч, хураагуурын ХүХ-н ялгаралт ба/буюу шингээлтийг тооцоолох шалгуур үзүүлэлт, журам, арга зүйг сонгон бий болгоно. (5.6-г үзнэ үү).

Сонгогдсон шалгуур үзүүлэлт, журмын дагуу төсөл хэрэгжүүлэгч ХүХ-н ялгаралт ба/буюу шингээлтийг дараахи зүйлүүдэд тус тусад нь тооцно:

а) Төслийн бүх ХүХ-н эх үүсвэр, шингээгч, хураагуур тус бүрт;

б) Суурь нөхцөлийн бүх ХүХ-н эх үүсвэр, шингээгч, хураагуур тус бүрт;

Мэдээ мэдээлэл хэтэрхий тодорхойгүй байх тохиолдолд төсөл хэрэгжүүлэгч ХүХ-н ялгаралтын бууралт эсвэл шингээлтийн өсөлтийг хэтрүүлэн тооцоолохгүй байх таамаглал, утгыг Сонгоно.

Төсөл хэрэгжүүлэгч төсөл болон суурь нөхцлийн ХүХ-н эх үүсвэр, шингээгч болон хураагуураас гарч байгаа ХүХ-н ялгаралт болон шингээлтийг тооцоолно. Гэхдээ эдгээр нь байнгын мониторинг хийгдэхээр сонгогдоогүй байх шаардлагатай.

Төсөл хэрэгжүүлэгч ХүХ-н ялгаралтын бууралт ба шингээлтийн өсөлтийн (ХүХ-н ялгаралтын бууралт, шингээлтийн өсөлтийн үргэлжилсэн байдал) тооцооллын эрсдэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт, журам, арга зүйг тодорхойлж практикт хэрэглэнэ.

Боломжтой тохиолдолд төсөл хэрэгжүүлэгч ХүХ-н ялгаралт, шингээлтийн итгэлцүүрийг дараахи байдлаар сонгон авах эсвэл тодорхойлно. Үүнд:

- Хүлээн зөвшөөрөгдсөн эх үүсвэрээс гаралтай байх
- Тохиромжтой ХүХ-н эх үүсвэр, шингээгчийг сонгосон байх
- Тооцоолол хийх цаг үетэй тохирч байх

- Тооцооллын тодорхой бус байдлыг анхааран үзэж нарийвчлал сайтай, дахин тооцоологдож болохуйц байх

-ХүХ-н тайлангийн зорилтот хэрэглээнд нийцэж байх

5.8 ХүХ-н ялгаралтын бууралт ба шингээлтийн өсөлтийг тооцоолох

Төсөл хэрэгжүүлэх явцад төслийн ХүХ-н ялгаралтын бууралт, шингээлтийг өсөлтийг тооцоолох шалгуур үзүүлэлт, журам, арга зүйг төсөл хэрэгжүүлэгч сонгох эсвэл бий болгоно.

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн ХүХ-н ялгаралтын бууралт болон шингээлтийн өсөлтийг тооцоолохдоо сонгон авсан арга зүй, шалгуур үзүүлэлт, журмыг даган мөрдөнө. ХүХ-н ялгаралтын бууралт болон шингээлтийн өсөлтийг ХүХ-н эх үүсвэр, шингээгч, хураагуурын суурь нөхцөл болон төсөл хэрэгжсэн үеийн хүлэмжийн хийн ялгаралт ба шингээлтийн өсөлтийн зөрөөгөөр тодорхойлно.

Төсөл хэрэгжүүлэгч нь төсөл болон суурь нөхцөл дэхь ХүХ-н ялгаралтын бууралт ба шингээлтийн өсөлтийг харгалзах эх үүсвэр, шингээгч, хураагуур тус бүрээр тооцон гаргана.

Төсөл хэрэгжүүлэгч ХүХ-ийн ялгаралтын бууралт ба шингээлтийн өсөлтийг тонноор илэрхийлэх ба ХүХ тус бүрийг дэлхийн дулаарын чадамжийг ашиглан тонн СО₂e нэгжид хөврүүлсэн утгаар илэрхийлнэ.

Тайлбар: Хавсралт Б хэсэгт Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх засгийн газар хоорондын мэргэжилтэний хорооноос гаргасан ДДЧ-ийг үзүүлэв.

5.9 Мэдээ, мэдээллийн чанарын удирдлага

Төсөл хэрэгжүүлэгч суурь нөхцөл болон төсөлтэй холбоотой түүнчлэн тодорхой бус байдлыг үнэлгээг батгаасан мэдээ, мэдээллийг удирдан зохицуулах чанарын менежментийн дүрэм журамыг боловсруулж мөрдөнө.

Төсөл хэрэгжүүлэгч ХүХ-н ялгаралтын бууралт болон шингээлтийн өсөлтийг тооцоолоход гарах тодорхой бус байдлыг хамгийн бага байлгахад анхаарч ажиллана.

5.10 ХүХ-н төсөлд мониторинг хийх

Төсөл хэрэгжүүлэгч төсөл болон суурь нөхцөлийн холбогдох ХүХ-н ялгаралт ба/буюу шингээлтийг тоолох, тайлагнахад шаардагдах мэдээ, мэдээллийг олж авах, тэмдэглэх, нэгтгэх, анализ хийх шалгуур үзүүлэлт, журмыг боловсруулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ. (жишээ нь, ХүХ-н мэдээллийн систем).

Мониторинг хийх журамд дараахи зүйлс орно. Үүнд:

- a) Мониторингийн зорилго,
- b) Тайлагнах мэдээ, мэдээллийн төрөл, тэдгээрийг хэмжих нэгжүүд,
- c) Мэдээний эх үүсвэр,
- d) Мониторинг хийх арга зүй. Үүнд: урьдчилан тооцоолох, загварчлах, хэмжих болон тооцоолох зэрэг аргачлалууд орно,
- e) Зорилтот хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн мониторинг хийх хугацаа, үечлэл,

MNS ISO 14064-2 : 2011

- f) Мониторинг хийх хүн ба түүний үүрэг хариуцлага,
- g) Мэдээг хадгалах газрын байршил, хадгалах хугацаа зэргийг тусгасан ХүХ-н мэдээллийн удирдлагын систем.

Хэмжилт, хяналтанд ямар нэг багаж төхөөрөмж хэрэглэсэн бол сайн туршлагын дагуу багаж төхөөрөмжид хөрвүүлэг, тохируулга хийхийг төсөл хэрэгжүүлэгч ханган ажиллана.

5.11 ХүХ-н төслийг баримтжуулах

Төсөл хэрэгжүүлэгч уг төсөл ISO14064 стандартын энэ хэсгийн шаардлагыг бүрэн хангасанаа батлах баримтийг бий болгоно. Энэ баримт нь магадлагаа, нотолгоо хийхэд тавигддаг шаардлагад нийцсэн байх ёстой (5.12-г үз).

5.12 ХүХ-н төслийн магадлагаа ба/буюу нотлогоо

Төсөл хэрэгжүүлэгч ХүХ-н төслийг магадлах, нотлох үүрэг хүлээнэ.

Хэрэв төсөл хэрэгжүүлэгч ХүХ-н төсөлд магадлагаа, нотолгоо хийлгэхийг хүсвэл төсөл боловсруулагч магадлагч, нотлогч нарт ХүХ-н мэдэгдлийг гаргаж өгөх ёстой.

Төсөл хэрэгжүүлэгч төслийн магадлагаа, нотлогоо ISO14064-3 стандартын шаардлага, зарчимын дагуу хийгдсэн байхад анхаарна.

5.13 ХүХ-н төслийг тайлагнах

Төсөл хэрэгжүүлэгч нь ХүХ-н тайланг зорилтот хэрэглэгчдэд зориулан боловсруулж, нээлттэй байлгана. ХүХ-н тайлан нь

- тайлангийн зорилтот хэрэглэгч, хэрэглээг тодорхойлсон байх

-зорилтот хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн агуулга, хэлбэрээр бичигдсэн байх шаардлагатай.

Хэрэв төсөл хэрэгжүүлэгч ХүХ-н мэдэгдлийг ISO14064-н энэхүү хэсгийн шаардлагын дагуу олон нийтэд мэдэгдэх тохиолдолд дараахи мэдээллийг ил тод байлгана. Үүнд:

a) ISO14064-3-д нийцүүлэн бие даасан гуравдагч этгээдийн гаргасан магадлагаа, нотлогооны тодорхойлолт, эсвэл

b) Хамгийн багадаа дараахи мэдээллийг агуулсан ХүХ-н тайлан. Үүнд:

1. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр;
2. ХүХ-н төсөлтэй холбогдох ХүХ-н хөтөлбөр(үүд);
3. ХүХ-н ялгаралтын бууралт ба шингээлтийн өсөлтийг тонн CO_{2e} нэгжээр илэрхийлсэн дүгнэлт бүхий ХүХ-н мэдэгдлийн жагсаалт;
4. Магадлагаа, нотолгооны хэлбэр, үнэмшлийн зэрэглэл г.м.-ийг агуулсан ХүХ-н мэдэгдэл нь магадлагдсан эсвэл нотлогдсон эсэхийг дурьдсан тодорхойлолт;
5. ХүХ-н төслийн хэмжээ, байршил, үргэлжлэх хугацаа, үйл ажиллагааны хэлбэр зэргийг багтаасан төслийн товч танилцуулга;
6. Тухайн хугацаан дахь (жилд, тухайн онгоо хүртэлх, нийт) төсөл хэрэгжүүлэгчийн хяналтанд байгаа төслийн ХүХ-н эх үүсвэр, шингээгч,

- хураагуурын нийт ХүХ-н ялгаралт ба/буюу шингээлтийг тонн CO₂e-ээр илэрхийлсэн мэдээлэл;
7. Тухайн хугацаанд суурь нөхцлийн ХүХ-н эх үүсвэр, шингээгч, хураагуурын нийт ХүХ-н ялгаралт ба/буюу шингээлтийг тонн CO₂e-ээр илэрхийлсэн мэдээлэл;
 8. Суурь нөхцлийн тодорхойлолт болон төсөл хэрэгжээгүй байх тохиолдолд ХүХ-н ялгаралтын бууралт ба шингээлтийн өсөлтийн хэмжээ ямар байхыг харуулах;
 9. ХүХ-ийн ялгаралтын бууралт ба шингээлтийн өсөлтийн үргэлжилсэн байдлын үнэлгээ (шаардлагатай тохиолдолд);
 10. Төслийн ХүХ-н ялгаралтын бууралт болон шингээлтийн өсөлтийг тооцоолоход ашигласан шалгуур үзүүлэлт болон журам эсвэл сайн туршлагын талаар ерөнхий тайлбар;
 11. Тайлангийн огноо ба тайлангийн хамрах хугацаа

Хавсралт А

(мэдээлэл)

ISO 14064 стандартын энэхүү хэсгийг хэрэглэх зааварчилгаа

А.1 Танилцуулга

Энэ хавсралт нь ISO14064-ийн энэ хэсгийг хэрэглэх зааварчилгаа юм. Энэ салбар маш хурдацтай хөгжиж байгаа тул стандартын шаардлагуудыг хэрхэн хэрэгжүүлэх тухай нарийвчлан энд өгүүлээгүй. Харин энэ зааварчилгаа нь ISO 14064-ийн энэ хэсэгт байгаа ойлголтууд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцийн Киотогийн протоколын төсөлд суурилсан механизмуудтай хэрхэн холбогдохыг тайлбарлах болно.

ISO 14064-ын энэ хэсгийг ХүХ-н төсөл хэрэгжүүлэгч, ХүХ-н төслийг үнэлэх магадлагч, нотлогч, ХүХ-н хөтөлбөрийн сайн дурын болон албан ёсоор томилогдсон менежерүүдийн хэрэглээнд зориулав. Энэ стандартыг төслийн төлөвлөлт болон хэрэгжилтийн үе шатанд хэрэглэж болно.

ISO 14064-ын энэ хэсэг нь тодорхой шалгуур үзүүлэлт, журам, дүрмийг санал болгохоос илүү үйл ажиллагаанд тавигдах шаардлага, түүнд тавигдах зарчмыг тодорхойлсон. Нэмэлт шаардлага, шалгуур үзүүлэлт, холбогдох ХүХ-н хөтөлбөрүүдийн зааварчилгаа, сайн туршлага, хууль эрх зүй, стандарт нь ISO14064-ийн энэ хэсгийг хэрэгжүүлэхэд онцгой ач холбогдолтой юм. Нэмэлт зааварчилгаа, хөтөлбөрт тавигдах шаардлага, сайн туршлага зэрэг нь олон эх сурвалжаас гаралтай бөгөөд байнга шинэчлэгдэн өөрчлөгдөж байдаг.

ISO 14064-ын энэ хэсэг нь саармаг ХүХ-н хөтөлбөрийн шинжтэй хэдий ч гадаад ба дотоод сайн дурын болон албан есны ХүХ-н хөтөлбөрүүдийн хэрэглээнд зориулж боловсруулав. Одоогийн байдлаар олон улсын болон үндэсний хэмжээний олон хөтөлбөр боловсруулалтын шатандаа явж байна. Зарим ХүХ-н хөтөлбөрүүд төслийн ХүХ-г үнэлэхтэй холбогдсон өөр нэмэлт шаардлагуудыг санал болгож байна.

ISO 14064-ын энэ хэсэг нь ХүХ-н төслийг магадлах ба нотлох, төслөөс бий болох кредитэд үнэлгээ өгөхийг шууд шаарддаггүй. Тиймээс төсөл хэрэгжүүлэгч ХүХ-н хөтөлбөрөөс гадна өөр нэмэлт зааварчилгааг дагах хэрэгтэй болдог. Уг төсөл хэд хэдэн ХүХ-н хөтөлбөрүүдтэй уялдан хэрэгжих тохиолдолд төсөл хэрэгжүүлэгч болон магадлагч, нотлогч нар тэдгээрийн нэмэлт шаардлагуудыг даган мөрдөх шаардлагатай.

Зураг А.1-т ISO 14064 стандартад хэрэглэсэн нүүрстөрөгчийн циклтэй холбоотой дараахи хэд хэдэн тодорхойлолтуудыг дүрслэн үзүүлэв.


- ХүХ-н эх үүсвэр
- ХүХ-н шингээгч
- ХүХ-н хураагуур
- ХүХ-н ялгаралт

-ХүХ-н шингээлт

А.2 Зарчмууд

А.2.1 Ерөнхий зүйл

ISO 14064-ын энэхүү хэсэг дэх зарчмууд нь төслийн ХүХ-н шингээлтийн өсөлт болон ялгаралтын бууралтыг баталгаатай, үнэн зөв, тэнцвэртэйгээр дүрслэхийг зорилго болгодог. Эдгээр зарчмууд нь стандартын шаардлагуудыг тайлбарлахад ашиглагддаг. Тухайлбал тавигдсан шаардлагуудыг хангах явцад шийдвэр гаргах, сонголт хийх тохиолдолд дурьдсан зарчмуудыг хэрэглэдэг. Зарчмууд нь ISO 14064-ын энэ хэсэгт шаардагдсан баталгаа, тайлбар хийх үндэслэл нь болно харин хэрэглэгч холбогдох зарчмуудыг хэрхэн хэрэглэсэн, ямар зарчмуудыг ашигласнаа ишлэл хийн тайлбарлах хэрэгтэй. Шүүн хэлцэж буй тухайн нөхцөл байдлаас хамаарч зарчим бүр өөр өөр байдлаар хэрэглэгдэж болно. Тухайн зарчим бүрийн зорилгыг харгалзан үзэж, бүхэлд нь зарчмуудад нийцсэн байдлаар хэрэглэх шаардлагатай. ISO 14064 -ийн энэ хэсэгт байгаа зарчмууд ISO14064-1-ийн хувьд түгээмэл боловч энэхүү хэсэгтээ бол онцгой зарчмийг агуулж байна.



Тайлбар:



t_1, t_2, t_3 - өөр өөр цаг хугацаанд

MNS ISO 14064-2 : 2011

Зураг А.1- Нүүрстөрөгчийн циклд хэрэглэгддэг үндсэн нэр томьёо ба тэдгээрийн харилцан үйлчлэл

А.2.2 Хамааралтай байдал

Хамааралтай байдал нь дараахи сонголтын хувьд нэн чухал юм. Үүнд :

- ХүХ-н төслийн болон суурь нөхцлийн ХүХ-н эх үүсвэр, шингээгч, хураагуур;
- ХүХ-н эх үүсвэр, шингээлт, хураагуурын ХүХ-н ялгаралт, шингээлтийг тооцоолох, мониторинг хийх, үнэлэх журмууд;
- Боломжит суурь нөхцөл

Хамааралтай байдлыг зорилтот хэрэглэгчдийн мэдээлэл, дүгнэлт, шийдвэрт хэрхэн нөлөөлсөнөөр үнэлдэг бөгөөд тоон болон чанарын шалгуураар тодорхойлдог. Жишээ нь, ХүХ-ийн бага ялгаруулагчдыг эх үүсвэрээр тооцоолох, ХүХ-н ялгаралт, шингээлтийг үнэлэх арга зүйг сонгох, ажиглалт хэмжилт хийсэн цэгийн тоо г.м.-д хамааралтай байдлын шалгуурыг тавьж болно. Хамааралтай байдлын зарчмыг хэрэгжүүлснээр ХүХ-н төслийн өртөгийг бууруулах ач холбогдолтой. Гэвч хэрэглэгчид шийдвэр гаргахын тулд найдвартай мэдээлэл дээр тулгуурласан тайлан болон тооцооллыг шаарддаг.

А. 2.3 Цогц байдал

Дараахи нөхцөлд мэдээллийн цогц байдал хангагддаг. Үүнд:

- Суурь нөхцөл болон төсөлтэй холбоотой, төслийн нөлөөлөл, хяналтан дор байх ХүХ-н эх үүсвэр, шингээгч, хураагуурыг тодорхойлох,
- Тогтмол хяналтанд байдаггүй ХүХ-н эх үүсвэр, шингээгч, хураагуурыг урьдчилан тооцох
- Зорилтот хэрэглэгчтэй хүссэн бүхий л мэдээлэл нь тодорхойлсон суурь нөхцөл ба төсөл, тайлангийн хамрах хугацаа, зорилго зэрэгт нийцсэн байдлаар төслийн мэдээ, мэдээллийн тайланд орсон байх,
- Суурь нөхцөлийг тухайн газар нутгийн байршил болон цаг үед тохируулан сонгосон байх.

Төслийн суурь нөхцөлд харгалзах ХүХ-н эх үүсвэр, шингээгч, хураагуур байхгүй тохиолдолд суурь нөхцлийн ХүХ-н ялгаралтыг тодорхойлоход тохиромжтой суурь утга, таамаглалыг хэрэглэж болно. Ийм бодит харьцуулалт хийх объект олдохгүй тохиолдолд ХүХ-н төслийн төлөвлөгөө, төслийн тайланд мэргэжилтэнүүд холбогдох баталгаа нотолгоог бий болгож тайлбарлах шаардлагатай болдог. Мөн түүнчлэн тохиромжтой загвар болон хөрвүүлэх итгэлцүүр ашиглах, тодорхой бус байдлыг урьдчилан үнэлэх шаардлагатай болдог. ХүХ-н шингээлтийн төсөлд адил шаардлага тавигдана.

А.2.4 Хоорондын уялдаа холбоотой байдал

Хоорондын уялдаа холбоотой байдал нь дараахи нөхцөлд хангагдана. Үүнд:

- Төслүүдэд нэг журмыг ашиглах
- Төсөл болон суурь нөхцөлд ижил журмыг ашиглах

- Жигд нэгж ашиглах. Жишээ нь төсөл болон суурь нөхцлийн ХүХ-г үнэлэхдээ ижил нэгж ашиглах
- Боломжит суурь нөхцлүүдэд ижил шалгуур, таамаглалуудыг ашиглах
- Цаг хугацаа ба төслийн явцад гадаад дотоод мэргэжилтэний үнэлгээ, дүгнэлт ижил байхыг хангах ёстой.

Хоорондын уялдаа холбоотой байдлын зарчим нь илүү нягт нямбай үйл ажиллагаа, арга зүйг бий болгон хэрэглэхээс сэргийлж байгаа хэрэг огт биш юм. Гэвч арга зүй болон журамд гарсан ямар нэгэн өөрчлөлтийг ил тодоор баримтжуулан хэрэглэж болно.

А.2.5 Үнэн зөв байдал

Тооцоолол доторх эх үүсвэрүүдээс гарсан алдааг арилгах, алдаанаас зайлсхийх, оновчтой байдал болон тодорхой бус байдлыг сайжруулснаар үнэн зөв байдал хангагдана.

Төсөл хэрэгжүүлэгч тодорхой хэмжээгээр үнэн зөв байдлыг бий болгох шаардлагатай боловч суурь нөхцлийн таамаглалаас шалтгаалан ХүХ-н ялгаралт ба шингээлтийн хэлбэрүүдийг хянах үйл ажиллагаа өртөг ихтэй байхаас гадна ихэнх тохиолдолд бусад хязгаарлалтууд үнэн зөв байдлыг тодорхойлоход бэрхшээл учруулдаг. Энэ тохиолдолд өмнө нь хэрэглэж байсан консерватив аргаа ашиглах нь төслийн ХүХ-н тооцооллын найдвартай байдлыг хадгалах зохицуулалт болж чадна.

Үнэн зөв байдал ба консерватив байдал нь өөр хоорондоо холбоотой зарчмууд юм. Төсөл хэрэгжүүлэгч үнэлгээн дэхь тодорхой бус байдлыг аль болох багасгасанаар ХүХ-н ялгаралт ба шингээлтийг консерватив зарчмаар тооцоологдох суурь утгыг сонгож болно.

А.2.6 Ил тод байдал

Мэдээлэл нээлттэй, тодорхой, баримт сэлтэнд тулгуурласан, дундыг баримтласан, өөр хоорондын уялдаа холбоотой байж тайлагнагдсан тохиолдолд ил тод байдал хангагдана. Дотоод аудитор болон гадны зорилтот хэрэглэгчид мэдээллийн найдвартай, үнэн зөв байдлыг шалгаж болохуйцаар мэдээллийг тэмдэглэж, цуглуулж, анализ хийсэн байх шаардлагатай. Ил тод байдал бий болгоход дараахи үйл ажиллагаа шаардлагатай. Үүнд:

- Бүх таамаглалыг тодорхой мэдээлэх, баримтжуулах
- Хэрэглэсэн материалуудын эх үүсвэрүүдийг тодорхой бичих
- Бүх тооцоолол, арга зүйг танилцуулах
- Баримтанд байгаа бүх өөрчлөлтүүдийг тодорхой тэмдэглэх
- Бие даасан магадлагч, нотлогч магадлагаа нотолгоо хийж болохуйцаар мэдээлэл цуглуулах, баримтжуулсан байх
- Зарчмуудын хэрэглээг баримтжуулах (жишээ нь суурь нөхцлийн сонголт хийхэд ямар зарчим ашигласан)
- Тайлбар, зөвтгөх үндэслэлээ баримтжуулах (жишээ нь журам, арга зүй, параметрууд, мэдээллийн эх үүсвэр, гол үзүүлэлт зэргийн сонголтыг хэрхэн хийсэн)

MNS ISO 14064-2 : 2011

- Сонгосон шалгуур үзүүлэлтүүдийн тайлбар баталгааг баримтжуулах (жишээ нь нэмэлт зүйл оруулах г.м)
- Бусад этгээд тайлагнасан мэдээ, мэдээллийг дахин гаргаж болох тооцоонд сонгож ашигласан таамаглал, тоон утга, арга зүйг баримтжуулах
- Зорилтот хэрэглэгчдийн шийдвэрт нөлөөлж болох төслийн гадаад хүчин зүйлсийг баримтжуулах

A.2.7 Консерватив байдал

Консерватив байдал дараахи нөхцөлд хангагдана. Үүнд:

- Технологийн хөгжлийн хандлагыг зөв илэрхийлэх, тухайн төсөл хэрэгжихгүй байх үеийн орон нутгийн хөгжил, цаг үеийн төлөв
- Төслийн технологийн хөгжил, орон нутгийн хөгжил, цаг үеийн төлөв байдалд үзүүлэх нөлөө
- Хөгжилд төслийн үзүүлэх үр нөлөө, холбогдох газарзүйн байрлал болон тодорхой хугацаан дахь хэрэгжилтийн түвшинг харгалзан үзэх
- Төслийн ХүХ-н ялгаралт, шингээлт, эх үүсвэр, шингээгч, хураагуур зэрэгт нөлөөлдөг параметруудийг зөв сонгох
- Боломжит таамаглалын хүрээнд найдвартай мэдээ, үр дүнг гаргах

Суурь нөхцлийг тодорхойлох, төслийн ХүХ-н ялгаралт болон шингээлтийг тооцоолоход ихээхэн тооны параметрууд болон мэдээний эх үүсвэрүүд нь тодорхойгүй байх тохиолдолд консерватив байдлын зарчмуудыг хэрэглэнэ. Таамаглал, арга зүй, параметр, мэдээний эх үүсвэр, суурь утга, ишлэл авсан, ашигласан материалын сонголтоос хамаарч суурь нөхцлийг консерватив байдлаар тодорхойлдог ба энэ тохилдолд суурь ялгаралт ба шингээлт нь бодит утгаас бага байх магадлалтай бөгөөд энэ нь эцсийн мэдээ, үр дүнгийн найдвартай байдлыг хангана. Консерватив зарчмуудыг хэрэглэнэ гэдэг нь хамгийн дундаж төсөөлөл, арга зүйг сонгож хэрэглэнэ гэсэн үг биш юм. Таамаглал болон арга зүй чухам аль талаараа консерватив болохыг төслийн баримтанд дурьдах хэрэгтэй. Консерватив зарчмуудыг ашиглахдаа ихэвчлэн тэнцвэрийг (үнэн зөв байдал, хамааралтай байдал, үр ашигтай байдал зэргийн хоорондох) хадгалах байдлаар хэрэглэх хэрэгтэй. Нарийвчлал багатай аргаар тооцоо хийсэн тохиолдолд илүү консерватив таамаглал эсвэл арга зүйг ашиглах шаардлагатай.

A.3 ХүХ-н төслүүдэд тавигдах шаардлага

A.3.1 Ерөнхий шаардлага

Төслүүд холбогдох стандарт, хууль дүрэм, сайн туршлагын дагуу хэрэгжих шаардлагатай. Төсөл эхлэхийн өмнө авах зөвшөөрөл болон стандарт, хууль дүрмийн дагуу ажиллах байдал нь төсөл шаардлага хангаж байгааг илтгэнэ. Төсөл хэрэгжүүлэгч төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн байдлын үнэлгээ хийлгэх, мөн тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмэр, түүнчлэн үндэсний байгаль орчин, хөгжлийн бодлого, стратегийн дагуу байгаа эсэхэд үнэлгээ дүгнэлт хийлгэсэн байх шаардлагатай.

ISO 14064 стандартын энэ хэсэг нь төслийн цар хүрээ, хэлбэрээс үл хамааран төсөлд тавигдах шаардлагуудыг тусгасан. Сайн туршлагын дагуу тавигдсан шаардлагыг хэрэгжүүлэхэд уян хатан байдлаар энэ стандарт бичигдсэн тул үүнийг

бүх төслүүдэд хэрэглэж болно. Зарим ХүХ-н хөтөлбөрүүд (жишээ нь Киотогийн дэглэм) нь жижиг хэмжээний төслүүдийг бусад төслүүдээс ялгаж хялбаршуулсан дүрмийг зааварчилгаа болгон ашиглахыг заасан байдаг. Киотогийн механизмыг зарим төрлийн төсөлд ашиглаж болно. Киотогийн механизмын төсөлтэй холбогдох шаардлагауудыг А.3.2 –д үзүүлэв.

А.3.2 Киотогийн механизм

А.3.2.1 Хамтарсан хэрэгжүүлэлт ба Цэвэр Хөгжлийн Механизм

А.3.2.1.1 Киотогийн дэглэмийн доор төсөлд суурилсан хоёр механизмийг бий болгосон юм. Үүнд :

- Цэвэр Хөгжлийн Механизм (ЦХМ) (ашигласан материал [4], Өгүүлэл 12-д үзүүлэв).
- Хамтарсан хэрэгжүүлэлт (ХХ) (ашигласан материал [4], Өгүүлэл 6-д үзүүлэв).

Киотогийн Протоколын шийдэрүүд нь 2005 оны 12 сарын талуудын бага хурлын шийдвэр дээр үндэслэгдсэн. Хэрэглэгч талуудын бага хурлын хамгийн сүүлийн шийдвэрүүдээс ишлэл татаж ашиглахыг зөвлөж байна.

А.3.2.1.2 ЦХМ-н журам болон бусад холбогдох мэдээллийг ашигласан номын жагсаалтыг (ашигласан материалын) [2]-оос, ойжуулалт ба ойг нөхөн сэргээх төслүүдийн талаах мэдээллийг [7]-д үзүүлэв. ЦХМ-н гүйцэтгэх зөвлөл ЦХМ-н хэрэгжилтийг хянах үүрэгтэйгээр байгуулагдсан бөгөөд төслүүдийг бүртгэх, суурь арга зүйг зөвшөөрөх зэрэг үүрэг гүйцэтгэдэг.¹⁾ Гүйцэтгэх зөвлөл нь зөвшөөрөгдсөн техникийн нэр томъёог боловсруулж тайлбар хийдэг. Томилогдсон магадлах байгууллага (ТМБ) нь ЦХМ-н гүйцэтгэх зөвлөлөөр итгэмжлэгдэх ба төслийн баталгаат ХүХ-н ялгаралтын бууралтыг (БЯБ) магадлан батлах эсвэл ЦХМ-н төслүүдийг магадлах үйл ажиллагааг явуулдаг бие даасан байгууллага юм. Төсөл магадлагдсаны дараа ТМБ төслийг бүртгүүлэх хүсэлт тавьдаг. Бүртгэл хийснээр магадлагдсан төсөл ЦХМ-ийн төсөл хэмээн албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөх болно. Бүртгэл нь төслийн үйл ажиллагаатай холбоотой ЯББ-ыг гаргаж өгөх, нотлогдсон гэрчилгээ олгох үйл ажиллагааны өмнөх шат юм. Киотогийн протоколын хүрээнд гэрчилгээ авах нь тухайн төслийн хугацаанд ХүХ-н ялгаралтыг бууруулж, шингээлтийг нэмэгдүүлсэн болох талаар албан ёсны баталгаа болдог. Зөвхөн ХүХ-н бууралтыг амжилттайгаар баталгаажуулсаны дараа гүйцэтгэх зөвлөл нь [ЯББ, буюу ойжуулалт ба ойг нөхөн сэргээх үйл ажиллагааны хувьд , түр хугацааны ба урт хугацааны ЯББ гэх] төсөлд оролцогчдод орлогын тодорхой хувийг хассан кредит олгодог Энэхүү орлогын тодорхой хувийг (ЯББ-н 2%) уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн өртөмтгий, эмзэг хөгжиж байгаа орнуудад тусламж болгон өгдөг. Нэн ядуу буурай орнуудад хэрэгжиж буй төслүүд энэ орлогын хувь өгөх үйл ажиллагаанаас чөлөөлөгдөнө. Түүнчлэн дараахи ханшаар тооцоологдсон удирдлагын зардлыг нөхөх бүртгэлийн хураамжыг төлөх шаардлагатай . Үүнд:

- Тухайн календарын жилд санал болгосон эхний, гэрчилгээт 15000 тонн CO₂e хэмжээний ХүХ-н ялгаралтын баталгаажсан бууралт тутамд 0.10 ам.дол
- Тухайн календарын жилд санал болгосон гэрчилгээт 15000 тонн CO₂e хэмжээнээс илүү ХүХ-н ялгаралтын баталгаажсан бууралт тутамд 0.20 ам.дол

MNS ISO 14064-2 : 2011

A.3.2.1.3 ХүХ-н кредитийг кредит олгох хугацаа буюу ХүХ-н ялгаралтын бууралт, шингээлтийн өсөлтийг магадлан нотолж, гэрчилгээ олгох хугацаанд л олгодог. ЦХМ-ын төслийн хувьд оролцогчид дараахи сонголтуудаас хугацааг сонгож болно.

- Ялгаралтын бууралтыг төслүүдийн хувьд ашигласан материалын [6]-д үзүүлэв, Хавсралт хуудас 37, догол мөр 49;
- Ойжуулалт ба ойг нөхөн сэргээх төслүүдийн хувьд ашигласан материалын [7]-д үзүүлэв, Хавсралт хуудас 21, догол мөр 23;

A.3.2.1.4 ЦХМ-н төсөл боловсруулах өртөгийг багасгахын тулд энгийн аргачлал, журмыг жижиг төслүүдэд хэрэглэж болно.

- Ялгаралтын бууралтын төслүүдэд ашигласан материалын [6]-г хар, шийдвэр хуудас 21, догол мөр 6;
- Ойжуулалт ба ойг нөхөн сэргээх төслүүдийн хувьд ашигласан материалын [7]-г хар, Хавсралт хуудас 16, догол мөр 1(i);

A.3.2.1.5 Хамтарсан хэрэгжүүлэлтийн (ХаХ) тохиолдолд хэрэглэж байгаа аргачлал, журмыг ашигласан материал [6]-гаас үзэж болно. (ХаХ)-ийн төслийн боловсруулалт, төсөл хүлээн авагч орны зөвшөөрөл нь төсөл хэрэгжих тухайн орноос хамаарч харилцан адилгүй байдаг. (ХаХ)-ийн төслийг удирдахын тулд протоколын оролцогч талуудын нэгдүгээр бага хурлаар Удирдлагын Хороо байгуулах шийдвэр гарсан.

A.3.2.2 Төсөлд тавигдах шалгуур үзүүлэлт

Киотогийн дэглэмд хамрагдах төслийг хүлээн авагч, төсөлд хөрөнгө оруулагч талууд болон төслийн үйл ажиллагаанд тавигдах тодорхой шаардлагуудыг Хүснэгт 1-т үзүүлэв.

Хүснэгт А.1 - Киотогийн механизмийн хүрээнд хэрэгжүүлэх төсөлд тавигдах шалгуур үзүүлэлт

Хэлбэр	Хамтарсан хэрэгжүүлэлт	ЦХМ		
		Энгийн ЦХМ	Жижиг хэмжээний ЦХМ	Шингээгчийн төсөл
Төсөл			Жижиг хэмжээний гэдэг тодорхойлолтод нийцсэн байх (Ашигласан материал [6], шийдвэр, хуудас 21, догол мөр 6)	Зөвхөн ойжуулалт ба ойг нөхөн сэргээх төслүүдийн үйл ажиллагаа багтана. Жижиг хэмжээний ЦХМ-ын төслүүдэд онцгой анхаарал хандуулна. (Ашигласан материал [7],

			Хавсралт, хуудас 16, догол мөр 1(i));
Зөвхөн Киотогийн Протоколын Хавсралт А-д үзүүлсэн хүлэмжийн хийн ялгаралт			
Оролцогч талуудын бичгээр өгсөн зөвшөөрөл/батламж (Ашигласан материал [5], Хавсралт хуудас 14, догол мөр 31 б)	Төсөлд оролцогч талуудын сайн дурын оролцооны талаар мөн тогтвортой хөгжихөд нь төслийн үйл ажиллагаа хувь нэмэр оруулж байгааг илэрхийлсэн төсөл хэрэгжүүлж байгаа талын батламж бичиг. (Ашигласан материал [6], Хавсралт ,хуудас 35, догол мөр 40а)		
	Төсвийн санхүүжилт хөгжлийн албан ёсны туслалцааг гуйвуулахгүй байх(Ашигласан материал [6], шийдвэр, хуудас 20)		
Нэмэгдэл чанар	Нэмэгдэл чанар (Ашигласан материал [6], Хавсралт ,хуудас 34, догол мөр 37д)	Нэмэгдэл чанар (Бэрхшээл болон тоон нотолгоо)	Нэмэгдэл чанар (Ашигласан материал [7], Хавсралт ,хуудас 18, догол мөр 12д)
Цөмийн байгууламжуудаас бий болох кредитээс зайлсхийх (Хамтарсан хэрэгжүүлэлт: Ашигласан материал[5], шийдвэр хуудас 5\ ЦХМ Ашигласан материал 6 шийдвэр хуудас 20)			Нүүрстөрөгчийн нөөцийн оргил үе болон нотологооны үе системтэйгээр давхцахаас зайлсхийх. Ашигласан материал[7], Хавсралт ,хуудас 18, догол мөр 12e)
2000 оноос эхэлсэн төслүүд 2008 оноос эхлэн кредит авч болно. (Ашигласан материал [8], анхны хувилбар шийдвэр, хуудас 6, догол мөр 5)	2000 оны 1 сарын 1-нээс 2004 оны 11 сарын 18-ны хооронд эхлээд хараахан бүртгүүлж амжаагүй гэхдээ 2005 оны 12 сарын 31-ний байдлаар томилогдсон магадлан итгэмжлэх байгууллагаар магадлагаа хийлгэх хүсэлт гаргасан эсвэл шинэ арга зүй өргөн мэдүүлсэн бөгөөд, 2006 оны 12 сарын 31-ний дотор гүйцэтгэх зөвлөлд бүртгэгдсэн бол өмнөх жилүүдийн кредитыг нөхөн шаардаж болно. (Ашигласан материал [10], догол мөр 4)		

		<p>Байгаль орчинд нөлөөлөх байдалд анализ хийх. Хүлээн авагч тал эсвэл төсөлд оролцогчид шаардсан тохиолдолд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх. (Ашигласан материал [6] Хавсралт, хуудас 34 догол мөр 4)</p>	<p>Хүлээн авагч тал шаардсан тохиолдолд байгаль орчинд нөлөөлөх байдалд анализ хийх</p>	<p>Биологийн төрөл зүйл, байгалийн экосистемд үзүүлэх нөлөөлөл болон төслийн хил хязгаараас гадна үзүүлэх нөлөөлөл, зэргийг хамарсан байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөлд анализ хийх</p> <p>(Ашигласан материал [7], Хавсралт, хуудас 18 ,догол мөр 12с)</p>
		<p>Оролцогч талуудын санал асуулгын талаар болон тэднээс гарсан санал, хүсэлтэд хэрхэн арга хэмжээ авсан талаар тайланг томилогдсон магадлах байгууллагад мэдээлэх (Хамтарсан хэрэгжилт: Ашигласан материал [5] Хавсралт, хуудас 14, догол мөр 32\ ЦХМ: Ашигласан материал [6] хуудас.34, догол мөр 37 б)</p>		
<p>Хүлээн авагч тал</p>	<p>Оролцогч тал нь хамгийн багадаа а-д-д тавигдсан шаардлагуудыг хангасан байх тохиолдолд хөрөнгө оруулагч талд тавигдах шаардлагыг үзнэ үү. (Хоёрдугаар арга) Хэрэв а-ж хүртэлх бүх шалгууруудыг хангах тохиолдолд нэгдүгээр аргыг хэрэглэх ба энэ нь өөрийн гэсэн нотолгооны дүрэм гаргаж болно. Ашигласан материал [5 Хавсралт] хуудас</p>	<p>Үндэсний эрх бүхий байгууллагыг томилсон. Ашигласан материал [5] Хавсралт хуудас 11, догол мөр 20а/ЦХМ</p>	<p>—Он” тухай ямар тодорхойлолт сонгон авсан тухайгаа гүйцэтгэх зөвлөлд мэдэгдэх. Үүнд: Титэмийн бүрхэцийн доод хэмжээ; талбайн доод хэмжээ; модны өндөрийн доод хэмжээ.</p> <p>Ашигласан материал [7] Хавсралт, хуудас 17,</p>	

	13, догол мөр 24		догол мөр 8	
	Киотогийн протоколыг соёрхон баталсан (Хамтарсан хэрэгжүүлэлт :Ашигласан материал 5, хавсралт , хуудас 12 догол мөр 21а/ ЦХМ: Ашигласан материал [6] Хавсралт, хуудас 32, догол мөр 31а)			
Хөрөнгө оруулагч тал	Хариуцагч этгээдийг томилсон (Ашигласан материал [5] Хавсралт, хуудас 11, догол мөр 20а)	Үндэсний эрх бүхий байгууллагыг томилсон (Ашигласан материал [6] Хавсралт, хуудас 32, догол мөр 30)		
	Киотогийн протоколыг соёрхон баталсан (Хамтарсан хэрэгжүүлэлт : Ашигласан материал 5 Хавсралт , хуудас 12, догол мөр 21а, ЦХМ :Ашигласан материал [6] Хавсралт, хуудас 32, догол мөр 31а)			
	Дүрэмд заасны дагуу оногдох хэмжээг тооцоолсон. (Хамтарсан хэрэгжүүлэлт : Ашигласан материал 5 Хавсралт , хуудас 12 догол мөр 21б, ЦХМ: Ашигласан материал [6] Хавсралт, хуудас 32, догол мөр 31б)			
	Дүрэмд заасны дагуу үндэсний бүртгэлтэй байгаа . (Хамтарсан хэрэгжүүлэлт : Ашигласан материал: 5 дугаар хавсралт , хуудас 12, догол мөр 21в, ЦХМ :Ашигласан материал [6] Хавсралт, хуудас 32, догол мөр 31в)			
	Дүрэмд заасны дагуу ялгаралтыг тооцоолох үндэсний системтэй болсон .(Хамтарсан хэрэгжүүлэлт : Ашигласан материал 5 Хавсралт , хуудас 12 догол мөр 21г, ЦХМ: Ашигласан материал [6] Хавсралт, хуудас 32, догол мөр 31г)			
	Дүрэмд заасны дагуу хамгийн сүүлийн үеийн шаардлагатай тооллогыг тоо баримтаар жил бүр мэдүүлсэн. (Хамтарсан хэрэгжүүлэлт : Ашигласан материал: 5 дугаар хавсралт , хуудас 12 догол мөр 21д, ЦХМ: Ашигласан материал [6] Хавсралт, хуудас 32, догол мөр 31д)			
	Дүрэмд заасны дагуу оногдох хэмжээтэй холбогдох нэмэлт мэдээллийг өргөн мэдүүлсэн. (Хамтарсан хэрэгжүүлэлт : Ашигласан материал 5 Хавсралт , хуудас 12 догол мөр 21е, ЦХМ: Ашигласан материал [6] Хавсралт, хуудас 32, догол мөр 31е)			
				Тоон хязгаар: Эхний үүрэгт хугацаанд хүлээн авагч орны суурь ялгаралтын 1%-ийг 5 дахин үржүүлснээс бага буюу тэнцүү байх

А.3.2.3 Цэвэр Хөгжлийн Механизмийн Төслийн Баримт Бичиг

ISO 14064-н энэ хэсэг дэхь ХүХ-н төслийн төлөвлөгөөнд тавигдах шаардлагууд нь Киотогийн Протоколын ЦХМ-д заагдсан төслийн баримт бичгийн (ТББ) агуулгатай ижил юм. Ашигласан материал 6 болон 9-ийн хавсралт Б-д төслийн баримт бичигт тавигдах шаардлагуудыг үзүүлсэн болно. ХүХ-н төслийн төлөвлөгөөний элементүүдээс гадна, ТББ т дараахи мэдээллүүд байхыг шаарддаг. Үүнд:

- Төслийн хүрээнд технологи дамжуулалт хийгдэх бол технологийн дамжуулалт хэрхэн хийгдэх талаарх тайлбар
- Төслийн үйл ажиллагааг төрөөс санхүүжүүлж байгаа бол энэ талаарх мэдээлэл
- Кредит авах хугацааны талаарх мэдээлэл

А.3.2.4 Бүтээгдхүүнтэй холбоотой ХүХ-н төслүүд

ХүХ-н төсөл бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаагаар хэрэгжиж болно. ХүХ-н ялгаралтын бууралт эсвэл ХүХ-н шингээлтийн өсөлт нь бүтээгдэхүүний (жишээ нь суурь бүтээгдхүүнээс илүү хөргөх чадвартай, бага энерги ашигладаг, агааржуулагч үйлдвэрлэх гэж үзвэл) амьдралын мөчлөгийн хэрэглээний шатанд ихэвчлэн тохиолддог. Иймээс бүтээгдэхүүнтэй холбоотой ХүХ-н төсөлд ХүХ-н ялгаралтын бууралт эсвэл ХүХ-н шингээлтийн өсөлтийг тооцоолоход амьдралын мөчлөгийн үнэлгээг (АМҮ) хэрэглэж болно ^[9].

А.3.3 Төслийн ХүХ-н эх үүсвэр, шингээгч, хураагуурыг тодорхойлох

А.3.3.1 Ерөнхий зүйл

Төсөл хэрэгжүүлэгч нь өөрийн хяналтанд байгаа холбогдох үйл ажиллагаа, төсөлтэй холбоотой болон төслийн нөлөөлсөн ХүХ-н эх үүсвэр, шингээгч, хураагуур зэргийг тодорхойлох шаардлагатай. Гэхдээ ХүХ-н ялгаралт ба шингээлтийг тооцоолоход боломжит бүх томоохон ХүХ-н эх үүсвэр, шингээгч болон хураагуур ихэнх тохиолдолд хамрагддаггүй. Бүгдийг нь хамруулдаггүй. Тиймээс төсөл хэрэгжүүлэгчид холбоотой гэхдээ хяналтанд нь байдаггүй ХүХ-н эх үүсвэр шингээгч болон, хураагуурыг тодорхойлох шалгууртай байх шаардлагатай юм.

Суурь нөхцөл болон төслийн үйл ажиллагааг харьцуулахын тулд (ХүХ ялгаралтын бууралт ба шингээлтийн өсөлт) үйлчилгээ, бүтээгдэхүүн, үйл ажиллагааг тоон хэмжигдэхүүнээр хянах хэрэгтэй болно.

Төсөл хэрэгжүүлэгч алдагдал гэж нэрлэгддэг зах зээлийн шилжилт, төслийн үйл ажиллагаанд орсон өөрчлөлтөөс болж үүссэн ХүХ-н эх үүсвэр, шингээгч болон хураагуурын ХүХ-н ялгаралт болон шингээлтэнд орсон өөрчлөлтийг хариуцна. Жишээ нь төсөл эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлсэнээр эрчим хүчний үнийг бууруулж эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлж (эргэх үр дагавар) болох юм. Сөрөг алдагдал гэж төслийн ХүХ-н эх үүсвэр, шингээгч нь ХүХ-н ялгаралтыг ихэсгэж, шингээлтийн өсөлтийг бууруулж байхыг хэлэх ба төслийн ХүХ-н эх үүсвэр, шингээгч нь ХүХ-н ялгаралтын бууралт, шингээлтийн өсөлтийг бий болгож байвал эерэг алдагдал гэж хэлдэг.

ISO 14064-н энэ хэсгийн зарим шаардлагыг биелүүлэх, нийцсэн эсэхээ баримтжуулахын тулд ХүХ-н эх үүсвэр, шингээгч, хураагуурыг зөв сонгоход туслах шийдвэр гаргах процессын жишээг Зураг А.2-т үзүүллээ. ХүХ-н ялгаралт болон шингээлтийг тооцоолох, байнгын хяналтанд авах, урьдчилан тооцоолоход ашиглах ХүХ-н эх үүсвэр, шингээгч, хураагуурыг сонгоход энэ загварыг хэрэглэнэ. Төсөл хэрэгжүүлэгчийн сонголтонд ашигласан шалгуур үзүүлэлтүүд нь ХүХ-н төслийн зарчмууд, сайн туршлагын зааварчилгаа, холбогдох ХүХ-н хөтөлбөрийн бодлого, дүрмүүд болон бусад холбогдох эх үүсвэртэй тохирч байх шаардлагатай. Төсөл хэрэгжүүлэгч үйл ажиллагаанд ашигласан шалгуур үзүүлэлтүүдийн сонголт, хэрэглэж байгаа журмуудын талаар (энэхүү жишээ эсвэл өөр хандлага хэрэглэгдсэн эсэх) тайлбар хийнэ. Жишээ нь ХүХ-н төслийн зарчмийн дагуу хэрэгжүүлэх боломж болон өртөгийн үр ашигтай байдал хоёрын хооронд тэнцвэр хэрхэн хангагдаж байгаа нь нэг шалгуур үзүүлэлт байж болно. Төсөл хэрэгжүүлэгч зарим шийдвэр гаргахдаа хэрэглэсэн хүчин зүйлсийг сайн туршлагын зааварчилгааны дагуу хийгдсэн болохыг батлан тайлбарлах шаардлагатай (хэрэв ХүХ-н эх үүсвэр, шингээгч, хураагуур нь төсөл болон суурь нөхцөлд орох, гарах материал ба энергийн урсгалаас хамаардаг бол). Энэ тохиолдолд төсөл хэрэгжүүлэгч эх үүсвэр, шингээгч, хураагуур (уурын тогоо бүрт, дулааны станц), ашигласан шалгуур үзүүлэлтүүд (оролтын бүтээгдэхүүний хэмжээ: өөрөөр хэлбэл солвент болон өдөөгч нь нийт масс бүрээгдэхүүний 5 хувиас илүү), эсвэл үнийн хувь хэмжээг (бүтээгдхүүн/үр дүн нь төслийн нийт төсөвийн 10%-тай тэнцэх бол) нэгдмэл байдлаар гаргахын тулд сайн туршлагын зааварчилгааг ашиглах нь зүйтэй юм. Эх үүсвэр, шингээгч, хураагуурыг хянах, тооцоолох тухай шийдвэр нь хяналтын зардал болон ХүХ-н зах зээлийн үнээс шууд хамаарч болно.

Байнгын хяналт болон тооцоололоос ХүХ-н эх үүсвэрийг хасах нь төсөл болон суурь эх үүсвэрүүдийн харьцуулахад суурь үйл ажиллагаанаас төсөл хүртэл ямар ч өөрчлөлт байхгүй байсантай холбон тайлбарлаж болох юм. ХүХ-н шингээлтийн өсөлтийг хангах төслийн хувьд төсөл хэрэгжүүлэгч ХүХ-н эх үүсвэр ба/буюу шингээгч нь төслийн хугацаанд төслийн нийт ХүХ-н ялгаралтанд нөлөө үзүүлдэггүй гэдгийг харуулж чадвал ХүХ-н эх үүсвэр ба/буюу шингээгчийг байнгын хяналт болон тооцоолох үйл ажиллагаанаас чөлөөлж болно.

холбоотой, төслийн нөлөөлөлд автагдаж байдаг эх үүсвэр, шингээгч, хураагуурууд орно. Нөлөөлөлд орсон болон холбоотой эх үүсвэрүүд нь Киотогийн механизмын нэр томъёогоор бол алдагдалыг үүсгэдэг. Энд хэрэглэж байгаа нэр томъёо нь ISO 14064-н энэхүү хэсгийг төрөл бүрийн хөтөлбөрүүдэд тохирхуйц дундыг сахисан байлгах зорилгоор төслийн “жил хязгаар”, —алдагдал” зэрэг тухайн хөтөлбөрийн онцлогт тохирсон тодорхойлолт өгөхөөс зайлсхийсэн болно. ISO 14064-н энэ хэсэгт болон Киотогийн механизмд хэрэглэсэн нэр томъёог Хүснэгт А.2-т харьцуулан үзүүлэв.

Хүснэгт А 2- Нэр томъёоны харьцуулалт

ISO14064-2 дахь холбогдох эх үүсвэр, шингээгч, хураагуур	Киотогийн протоколын харгалзах ангилал (Ашигласан материал [6], Хавсралт, хуудас 37, догол мөр 51,52)
А. Хяналтанд байгаа Б. Төсөлд холбогдох В.Төслийн нөлөөлөлд өртсөн	- Шууд хамааралтай (төслийн хил хязгаарын дотор) -Шууд хамааралтай (төслийн хил хязгаар дотор) - Хэрэв (төслийн хил хязгаараас гаднах) ялгаралт нь ХүХ-н төслөөс үүдэлтэй бол алдагдлыг тооцоонд оруулах шаардлагатай. - Хэрэв (төслийн хил хязгаараас гаднах) ялгаралт нь ХүХ-н төслөөс үүдэлтэй бол алдагдлыг тооцоонд оруулах шаардлагатай.

А.3.4 Суурь нөхцлийг тодорхойлох

А.3.4.1 Суурь нөхцлийн сонголт

Суурь нөхцлүүд нь санал болгож байгаа төслийг хэрэгжихгүй тохиолдолд ХүХ-н ялгаралт, шингээлт ямар байх байсныг урьдчилан таамаглах боломж олгоно. Төсөл өөрөө суурь нөхцөл ч байж болох юм. Төсөл суурь нөхцөл биш болохыг харуулахын тулд төслийн төлөвлөлтийн үе шатанд уг төслийг суурь нөхцөл гэж авч үзэхийг төсөл хэрэгжүүлэгчид зөвлөж байна. Хэрэв төсөл нь суурь нөхцөл байвал ХүХ-н ялгаралтын бууралт эсвэл шингээлтийн өсөлт байхгүй болох эрсдэлтэй юм. Иймээс санал болгож буй төсөл нь хүчин төгөлдөр ХүХ-н төсөл болж чадахгүйг анхаарах шаардлагатай.

ХүХ-н ялгаралтыг хэт ихээр тооцоолох эрсдэлтэй тохиолдолд олон суурь нөхцлийг чанартайгаар тооцоолох арга хэрэглэх хэрэгтэй. ХүХ-н ялгаралтын бүх боломжит суурь нөхцлийн хувилбаруудыг гаргахыг зорих шаалдлагатайгаас гадна сонгосон суурь нөхцөл нь төслийн хугацаанд, бүхий л төсөөлөл, таамаглалын царааг илэрхийлэхүйц байхаар сонголт хийгдсэн байх шаардлагатай. Цогц байдал, хамааралтай байдал, ил тод байдал, хоорондын уялдаа холбоотой байдлаар адил боломжит хувилбаруудаас консерватив хувилбарыг ихэвчлэн сонгодог . Суурь нөхцөл нь төсөл хэрэгжүүлэх хугацаатай ижил хугацааг хамрах шаардлагатай.

MNS ISO 14064-2 : 2011

Жишээ нь газрын гадаргын ХүХ-н шингээлтийн төслүүд нь зөвхөн сонгосон ХүХ-н төрлүүдийг ашиглан суурь нөхцлийг үнэлэх тохиолдол бий. Тооцоо хийхдээ зөвхөн ХүХ-н хураагуур болон нүүрсхүчлийн хийн санд хуримтлагдсан нийт нүүрстөрөгчийн хийн нөөцийн өөрчлөлтийн нэмэгдлийг авч үздэг. Эцсийн ХүХ-н шингээлтийн өсөлт нь ХүХ-н эх үүсвэрүүдээс гарах бүх ХүХ-н ялгаралтын өсөлтөөс нүүрсхүчлийн хийн сан болон хураагуурт хуримтлагдсан нийт ХүХ-н хэмжээний өөрчлөлтийн нийлбэр утгаар гарна.

А.3.4.2 Суурь нөхцлийн ХүХ-н ялгаралт ба шингээлтийг урьдчилан тооцох

Суурь нөхцлийн ХүХ-н ялгаралтыг тооцоолох аргачлал, журам нь ерөнхийдөө төсөлд тохирсон (жишээ нь: төсөл хэрэгжүүлэгч боловсруулсан) эсвэл стандартчлагдсан (жишээ нь: төсөл хэрэгжүүлэгч эсвэл ХүХ-н хөтөлбөрийн удирдах байгууллага тодорхой төрлийн төсөлд зориулан боловсруулсан) байдаг.

Түүхэн буюу өмнөх нөхцөл байдал (ХүХ-н ялгаралт эсвэл үйл ажиллагааны тухай мэдээ, мэдээлэл г.м), зах зээлийн нөхцөл байдал (энгийн технологи хэрэглэх г.м), хамгийн сайн технологи (ижил үйл ажиллагаа явуулдаг хамгийн сайн төслийн эхний 20% нь хэрэглэдэг технологи г.м) зэрэг нь суурь нөхцлийг тодорхойлох аргачлалыг сонгох үндэс болдог. Суурь нөхцөл нь хөдөлгөөнгүй (цаг хугацааны хувьд өөрчлөгдөхгүй, тогтмол байх) эсвэл хөдөлгөөнтэй (цаг хугацааны хувьд өөрчлөгдөж) байж болно.

ХүХ-н хөтөлбөрүүд ХүХ-н шингээлтийн зарим төслүүдийн суурь нөхцлийг үнэлэхдээ хялбаршуулсан арга хэрэглэж болно. Тухайлбал: тухайн газар ашиглалтын төрлөөс хамаарч ойжуулах, ойг нөхөн сэргээх төслийн суурь нөхцлийг сонгохдоо өмнө нь газар ашиглалт байгаагүй байсан гэж үзэн нүүрстөрөгчийн баланс нь тэгтэй тэнцэнэ гэвэл шингээлтийг тэг гэж авч үзэж болно. Ийм байдлаар төслийн суурь нөхцлийг шийдэх тохиромжтой стандартыг бий болгож болно.

А.3.4.3 Киотогийн Механизмууд: Суурь нөхцөл

Киотогийн дэглэмд хамааралтай төслийн баримт бичигт суурь нөхцлийг дараахи 3 арга замаар шийдэж болно. Үүнд:

- а). Одоо байгаа бодит эсвэл түүхэн буюу өмнөх ХүХ-н ялгаралт
- б). Хөрөнгө оруулалтын саад бэрхшээлийг харгалзасны үндсэн дээр эдийн засгийн хувьд ашигтай байх үйл ажиллагааг төлөөлөх технологиос ялгарах ХүХ-н ялгаралт
- с). Адил төстэй нийгэм, эдийн засаг, байгаль орчин, технологийн нөхцөл байдалд өмнөх 5 жилд хэрэгжсэн өөрийн ангилалдаа хамгийн сайн эхний 20%-д багтсан төслүүдээс ялгарах ХүХ-н дундаж ялгаралт.

Тухайн төсөл нь нэмэгдэл чанартай гэдгийг харуулахын тулд төсөл саанаачлагч нь бүртгэгдсэн төслийн ХүХ-н эх үүсвэрээс ялгарах ялгаралт нь төсөл хэрэгжээгүй тохиолдолд үүсэх байсан ялгаралтаас хэрхэн буурсан болохыг тайлбарлах хэрэгтэй болдог.

Киотогийн механизмын дагуух төслийн суурь нөхцлийн тухай мэдээллийг ашигласан материалын 6-ийн 43-48 дугаар догол мөрөөс, ЦХМ-ын ойжуулалт болон ойг нөхөн сэргээх төслийн суурь нөхцөлийн тухай мэдээллийг ашигласан материалын 7-ын 19-22 дугаар догол мөрнөөс тус тус уншиж болно.

А 3.5 ХүХ-н ялгаралт ба/буюу шингээлтийг тооцоолох

ХүХ-н ялгаралт эсвэл шингээлтийг тооцоолох эхний алхам нь ХүХ-н эх үүсвэр, шингээгч, хураагуурыг тодорхойлох явдал юм. Төсөл хэрэгжүүлэгчид байгаа мэдээ, мэдээллийн боломжоос хамаарч ХүХ-н ялгаралт, шингээлтийг урьдчилан тооцох эсвэл тооцоолдог. Жишээ нь, төслийн үйл ажиллагаа эхлэхийн өмнө ХүХ-н ялгаралт, шингээлтийг урьдчилан тооцох ба харин төслийн үйл ажиллагаа эхлэсэн үед ХүХ-н ялгаралт, шингээлтийг шууд хянах, хэмжих замаар ХүХ-н ялгаралт, шингээлтийг тооцоолдог.

Тогтвортой байдал гэдэг нь байгаль орчин болон удирдлагын боломжит өөрчлөлтөнд ХүХ-н хураагуур болон нүүрсхүчлийн сангийн хураах чадвар урт хугацаанд хэр тогтвортой байгааг үнэлэх шалгуур үзүүлэлт юм. Биологийн шингээгч гэдэг ойлголттой холбогдуулан тогтвортой байдлыг Киотогийн протоколд хэрхэн тодорхойлсныг ашигласан материалын 7-ын 38-50 дугаар догол мөрнөөс уншиж болно.

ХүХ-ийн ялгаралтын бууралт, шингээлтийн өсөлтийг хэтрүүлэн тооцоолохгүйн тулд дахин тооцоолж болно. Дахин тооцоолох ажлыг төслийн хэрэгжилтийн үед төсөл хэрэгжүүлэгч дахин хийх шаардлагатай (жишээ нь: мэдээ мэдээллийн нарийвчлал сайжирсан) гэж үзсэн тохиолдолд хийж болно. Дахин тооцоо хийх ажилийг төсөл хэрэгжсэнээс хойшхи төслийн бүх хугацаанд хийж болно.

Газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлт, ойжуулах төслийн сайн туршлагын зааварчилгааны талаар нэмэлт мэдээллийг ашигласан материал 12-ын 4.3 дугаар бүлгээс уншиж болно.

А.3.6 Мэдээллийн чанарын удирдлага

Дараахи үйл ажиллагааг гүйцэтгэсэнээр мэдээ, мэдээллийн чанарын удирдлага сайжирна. Үүнд:

- Бүрэн төгс ХүХ-н мэдээллийн систем бий болгон байнгын ажиллагааг хангах
- Техникийн алдааг тогтмол хугацаанд шалгах
- Тодорхой цаг хугацаанд техникийн үзлэг болон дотоод аудит хийх
- Төслийн гишүүдэд тохирсон сургалт зохион байгуулах
- Тодорхой бус байдлын үнэлгээ хийх

Тодорхой бус байдлын үнэлгээ нь чанарын (дээд, дунд, доод) болон тоон үзүүлэлтээр хийгдэх ба энэ нь статистик нарийвчилсан тооцоо хийх болон системчлэгдсэн дүрэм журмын дагуу хийгддэг тодорхой бус байдлыг үнэлэх анализаас илүү хялбар юм. Ерөнхийдөө тодорхой бус байдлын үнэлгээг төслийг төлөвлөх үе шатанд, тодорхой бус байдлын анализыг төсөл хэрэгжүүлэх үе шатанд хийх нь зүйтэй. Төслийн хэрэгжилтийн явцад тодорхой бус байдлын анализ хийх хэрэгцээтэй эсэхийг ХүХ-н хөтөлбөрийн оролцогч тал шийднэ. ХүХ-н хөтөлбөрөөс гадна ISO 14064 стандартын энэхүү хэсгийг хэрэглэх тохиолдолд тодорхой бус байдлын анализ хийхийг зөвлөж байна.

Ашиглах материалын 12-ын 4.3.4 бүлэгт газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлт, ойжуулах төслийн мэдээллийн чанарт тавигдах хяналт, уирдамжын талаар сайн туршлагын зааварчилгааг жишээ болгон үзүүлсэн болно.

А 3. 7 ХүХ-н төсөлд мониторинг хийх

А. 3. 7. 1 Ерөнхий зүйл

Мониторинг хийх дүрэм, журамд суурь нөхцөл ба төслийн ХүХ-н мэдээ, мэдээллийг цуглуулах, тооцоолох, хэмжих, нэгтгэх, тайлагнахад хэрэглэх аргачлал, хяналт хийх төлөвлөгөө, үүрэг, хариуцлага, багаж төхөөрөмж, хүний нөөц зэргийг тусгана.

А. 3. 7. 2 Киотогийн механизм: Мониторинг хийх

Киотогийн протоколын ЦХМ-ын төслийн мониторингийн үйл ажиллагааг CP.7-ын 17-р шийдвэрийн хавсралтад заасны дагуу хэрэгжүүлнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг 38 дугаар хуудсан дахь 53-60 дахь догол мөр, ашигласан материалын 6-гаас уншиж болно. Гүйцэтгэх зөвлөлийн баталсан мониторинг хийх аргачлалыг <http://cdm.unfccc.int/methodologies/approved> гэсэн цахим хаягаас олж уншиж болно. Төслийн баримт бичигт шаарддаг мониторингийн төлөвлөгөөг хавсралт 4-ийн ашигласан материал 9-д үзүүлсэн болно. Ашигласан материалын 7-ын 21 дүгээр хуудасны 25-30 дугаар догол мөрд ойжуулах болон ойг нөхөн сэргээх төслийн ЦХМ-ын мониторинг хэрхэн хийх мэдээллийг үзүүлсэн болно.

Ашиглах материалын 12-ын 4.3.4 бүлэгт газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлт, ойжуулах төслийн мэдээллийн чанарт тавигдах хяналт, уирдамжийн талаарх сайн туршлагын зааварчилгааг жишээ болгон үзүүлэв.

А 3.8. ХүХ-н төслийг баримтжуулах

ISO 14064-ийн энэ хэсэг дотоод аудит, магадлагаа, нотолгоо хийх дотоод хэрэгцээтэй холбоотой мэдээллийг хэрхэн баримтжуулах талаар өгүүлсэн. Энэ нь гадаад хэрэгцээ, шаардлагад зориулсан баримтжуулах ажиллагаа юм.

Төслийн ХүХ-н мэдээ, мэдээлэл болон төслийн мэдээллийн систем ба ХүХ-н мэдээллийн системтэй нягт уялдаатай болох энэхүү баримтжуулах үйл ажиллагаа нь бүрэн гүйцэд, ил тод байна.

А.3.9 ХүХ-ийн төслийг магадлах/ нотлох

ISO14064 стандартын энэ хэсэг төслийн ХүХ-н магадлагаа, нотолгоог шаарддаггүй. Энэ шаадлага нь ХүХ-н хөтөлбөрийн нэг элемент нь юм. Хэрэв уг төсөл ХүХ-н хөтөлбөртэй уялдаагүй бол төсөл хэрэгжүүлэгч нь ХүХ-н магадлагаа, нотолгооны төрөл (анхдагч, хоёрдагч, гуравдагч талын нотолгоо), ХүХ-н мэдэгдлийн үнэн зөв байдлын түвшинг (дээд ба дунд) шийдэх хэрэгтэй болдог. ХүХ-н мэдэгдэл нь төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс хийсэн ХүХ-н төслийн гүйцэтгэлийн тухай тодорхойлолт юм. ISO 14064 стандартын 3 дугаар хэсэгт ХүХ-н мэдэгдлийг магадлах, нотлох шаардлага, зарчмыг тодорхойлсон болно.

3. 10 ХүХ-ийн төслийг тайлагнах

А.3.10.1 Ерөнхий үндэслэл

ХүХ-н төслийн мэдээллийг зорилтот хэрэглэгчидэд тайлагнах шаардлагатай. Тайлангийн хэлбэр, агуулга нь зорилтот хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна. Төслийн нөхцөл байдал, тайлагнах зорилго, зорилтот хэрэглэгчийн хэрэгцээт мэдээлэл, хамрагдаж буй хөтөлбөрийн шаардлага зэргээс хамаарч төсөл хэрэгжүүлэгч нь төслийн тайлагнах журмыг боловсруулж болно. Ямар ч тохиолдолд тайлан нь ХүХ-н төслийн баримтжуулалтад тулгуурлана.

ХүХ-н төслийн олон нийтэд түгээсэн ХүХ-н мэдэгдэл нь ISO 14064-ийн энэхүү хэсгийн хүрээнд байгаа гэж тодорхойлсоноос бусад тохиолдолд ISO 14064-ийн энэхүү хэсэгт төсөл хэрэгжүүлэгч нь ХүХ-н тайланг олон нийтэд ил тод тайлагнахыг шаарддаггүй. Ийм тохиолдолд ХүХ-н тайлан нь цогц, үнэн зөв, ил тод байдал зэрэг наад захын шаардлагыг хангасан байх ёстой. Бүх тохиолдолд төслийн тайланг ХүХ-н төслийн баримт бичиг дээр тулгуурлан боловсруулна. Олон нийтэд түгээсэн мэдээлэл нь янз бүрийн төслүүдийг хооронд нь харьцуулах боломжийг олгохуйц байх шаардлагатай.

Олон нийтэд санал өгөх боломж олгох, мэдээллийн ил тод байдлыг сайтар хангах нь төслийн үр дүнг ихэсгэх төдийгүй төслөөс бий болох кредитийн үнэ цэнийг зах зээл дээр тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэнэ. Түүнчлэн төслийн мэдээллийг ил тод байлгах нь төслийн боловсруулалт, хэрэгжүүлэлт болон түүний удирдлага, зохион байгуулалтанд өгөх оролцогч талуудын үнэтэй санал, зөвлөмжийг авах ач холбогдолтой. Мөн төсөл хэрэгжүүлэгч нь төслийн талаар олон нийтэд сурталчилах зорилгоор уг тайланг ашиглаж болно.

А.3.10.2 Киотогийн Механизм: Тайлагнах

Үйл ажиллагаа явуулагч этгээд төслийн баримт бичиг ба нотолгооны тайланг олон нийтэд ил тод байлгах ёстой. (Ашигласан материал (6), Хавсралтын 36 дугаар хуудас, догол мөр 40 b-g-д үзүүлэв).

Ойжуулах, ойг нөхөн сэргээх төсөлийг тайлагнахтай холбоотой сайн туршлагын зааварчилгааг ашигласан материал 12-ын 4 дүгээр бүлгийн 4.48 хуудасны Хүснэгт 4.2.6с-д үзүүлэв.

Хавсралт Б (мэдээлэл) Хүлэмжийн хийн Дэлхийн Дулаарлын Чадамж

Хүснэгт Б.1-т Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх засгийн газар хоорондын мэргэжилтний хорооноос 1996 онд хэвлэн гаргасан Үндэсний хэмжээний хүлэмжийн хийн тооллогыг тайлагдгах зааварчилгаанд заасан янз бүрийн хийн 100 жилийн турш үзүүлэх Дэлхийн дулаарлын чадамжийн утгыг харуулав[11].

Хүснэгт Б.1

Хий	Химийн томъёо	Дэлхийн дулаарлын чадамж, IPCC1996
Нүүрсхүчлийн хий	CO ₂	1
Метан (Намгийн хий)	CH ₄	21
Азотын исэл	N ₂ O	310
Устфторт нүүрстөрөгчийн нэгдэл (HFCs)		
HFC-23	CHF ₃	11 700
HFC-32	CH ₂ F ₂	650
HFC-41	CH ₃ F	150
HFC-43-10төө	C ₅ H ₂ F ₁₀	1 300
HFC-125	C ₂ HF ₅	2 800
HFC-134	C ₂ H ₂ F ₄ (CHF ₂ CHF ₂)	1 000
HFC-134a	C ₂ H ₂ F ₄ (CH ₂ FCF ₃)	1 300
HFC-143	C ₂ H ₃ F ₃ (CHF ₂ CH ₂ F)	300
HFC-143a	C ₂ H ₃ F ₃ (CF ₃ CH ₃)	3 800
HFC-152a	C ₂ H ₄ F ₂ (CH ₃ CHF ₂)	140
HFC-227ea	C ₃ HF ₇	2 900
HFC-236fa	C ₃ H ₂ F ₆	6 300
HFC-245ca	C ₃ H ₃ F ₅	560
Устфторт этирийн нэгдэл (HFEs)		
HFE-7100	C ₄ F ₉ OCH ₃	500
HFE-7200	C ₄ F ₉ OC ₂ H ₅	100
Перфторт нүүрстөрөгчийн нэгдэл (PFCs)		
Perfluoromethane (tetrafluoromethane)	CF ₄	6 500
Perfluoroethane (hexafluoroethane)	C ₂ F ₆	9 200
Perfluoropropane	C ₃ F ₈	7 000
Perfluorobutane	C ₄ F ₁₀	7 000
Perfluorocyclobutane	c-C ₄ F ₈	8 700
Perfluoropentane	C ₅ F ₁₂	7 500
Perfluorohexane	C ₆ F ₁₄	7 400
Sulfur hexafluoride	SF ₆	23 900

Ашигласан материал

- [1] ISO 14040:1997, *Environmental management — Life cycle assessment — Principles and framework*
- [2] ISO 14064-3:2006, *Greenhouse gases — Part 3: Specification with guidance for the validation and verification of greenhouse gas assertions*
- [3] ISO 14065:—3), *Greenhouse gases — Requirements for greenhouse gas validation and verification bodies for use in accreditation or other forms of recognition*
- [4] United Nations Framework Convention on Climate Change. The Kyoto Protocol to the Convention on Climate Change, 1998
- [5] United Nations Framework Convention on Climate Change. Report of the Conference of the Parties on its Seventh Session, Held at Marrakesh from 29 October to 10 November 2001, FCCC/CP/2001/13/Add.2, Decision 16/CP.7, Guidelines for the Implementation of Article 6 of the Kyoto Protocol, 21 January 2002 (available from <http://unfccc.int/>)
- [6] United Nations Framework Convention on Climate Change. Report of the Conference of the Parties on its Seventh Session, Held at Marrakesh from 29 October to 10 November 2001, FCCC/CP/2001/13/Add.2, Decision 17/CP.7, Modalities and Procedures for a Clean Development Mechanisms as defined in Article 12 of the Kyoto Protocol, 21 January 2002 (available from <http://unfccc.int/>)
- [7] United Nations Framework Convention on Climate Change. Report of the Conference of Parties on its Ninth Session Held at Milan From 1 to 12 December 2003, FCCC/CP/2003/6/Add.2, Decision 19/CP.9 Modalities and Procedures for Afforestation and Reforestation Project Activities under the Clean Development Mechanism in the First Commitment Period of the Kyoto Protocol, 30 March 2004 (available from <http://unfccc.int/>)
- [8] United Nations Framework Convention On Climate Change. Clean Development Mechanism Executive Board, Clean Development Mechanism Guidelines for Completing the Project Design Document for A/R (CDM-AR-PDD), the Proposed New Methodology for A/R: Baseline (CDM-AR-NMB) and the Proposed New Methodology for A/R: Monitoring (CDM-AR-NMM), September 2004 (available from <http://cdm.unfccc.int/EB>)
- [9] United Nations Framework Convention on Climate Change. Clean Development Mechanism Executive Board, Project Design Document Form (CDM-PDD), Version 02, July 2004 (available from <http://unfccc.int/>)
- [10] United Nations Framework Convention on Climate Change. Decision CMP.1 Further Guidance Relating to the Clean Development Mechanism, December 2005 (available from http://unfccc.int/files/meetings/cop_11/application/pdf/cmp1_24_4_further_guidance_to_the_cdm_ebcmp_4.pdf)
- [11] Intergovernmental Panel on Climate Change. Revised 1996 IPCC Guidelines for National Greenhouse Gas Inventories Reporting Instructions, 1997 (available from <http://www.ipcc.ch/>)
- [12] Intergovernmental Panel on Climate Change. Good Practice Guidance for Land Use, Land Use Change and Forestry, 2003 (available from <http://www.ipcc.ch/>)

MNS ISO 14064-2 : 2011

[13] World Resources Institute (WRI) and World Business Council for Sustainable Development (WBCSD), 2005, The GHG Protocol for Project Accounting, Washington, DC:WRI/WBCSD4)